

著者(英)	Yuki Konagaya, S. Chuluun
journal or publication title	Senri Ethnological Reports
volume	10
page range	9-63
year	2013-02-01
URL	<a href="http://doi.org/10.15021/00008876">http://doi.org/10.15021/00008876</a>

## САНГИЙН АЖ АХУЙ

- |                                    |   |
|------------------------------------|---|
| 1. Байрлал одоогийн газрын нэр сум | 5. Тухайн үеийн хүмүүсийн нэр, мэдээлэл, эхэн үеийн дарга нар |
| 2. Байгуулагдсан он                | 6. Үйлдвэрийн мэдээлэл статистик                              |
| 3. Татан буугдсан он               | 7. Онцлог түүх  |
| 4. Газрын нэр сонголт              | 8. Хамаатай ном судалгаа.                                     |

### 1. Баяннуур

1. Баян-Өлгий аймгийн Баяннуур сум.
2. 1961 онд СнЗ-ийн 57-р тогтоолоор байгуулагдсан.
3. 1992 он.
4. “Баяннуур” хэмээх газрын нэрээр нэрийдсэн.
5. 1991 онд Хөдөлмөрийн баатар болсон ямаачин И.Сасызбай тус САА-д ажиллаж байжээ.
6. Анх байгуулагдахдаа авто машин 7 трактор 6, сеялка 7, төмс суулгагч 3 цахилгаан станц 2, ажилчин албан хаагч 68-тай, найман тооны эсгий гэртэй байжээ. Байгуулагдсан жилдээ 158 үнээтэй саалийн ферм байгуулан түүнийг тэжээлээр хангахын тулд 316, 7 га газар үр тариа, 45,7 га газар төмс, ногоо, 38 га газар тэжээлийн ургамал тариалжээ. 1962 онд шувууны фермтэй болж, 1962-1963 онуудад 318 га атар газрыг нээн ашигласан ба 1374 үхэр, 2544 хонь, 402 адуу бүгд 4320 тооны үржлийн малтай болжээ.
7. Баян-Өлгий аймаг дахь сум, дундын тэжээлийн аж ахуй.
8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдагва, УБ, 1998.  
Баян-Өлгий аймгийн түүх, А.Минис, УБ, 1969.

### 2. Ногоон нуур

1. Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутаг.
2. Ногооннуур сумыг 1952 онд Цагааннуур сумын 1,5,6,8,14 дүгээр багуудаар байгуулжээ. 5,2 мян.км<sup>2</sup> нутаг дэвсгэртэй, 6539 хүн амтай, хүн амын 90% казахууд эзэлдэг.  
1968 онд Баян-Өлгий аймгийн сумдыг хадлангаар хангах зорилгоор анх байгуулагдсан байна.
3. 1992 онд хувьчлагдсан.
4. Тус сумын нутагт орших Ногооннуурын нэрээр нэрлэгдэв.

- 5.
6. 1976 оны байдлаар тус тэжээлийн аж ахуйд 75 өрхийн 501 хүн ажиллаж амьдарч байжээ. Адууны нэг, хонь ямааны 4 суурьтай, 2618,9 төгрөгийн үндсэн хөрөнгөтэй.
7. Ногоонуур суманд Монгол улсын эдийн засгийн 3-дахь чөлөөт бүс Цагаануурын чөлөөт бүс байрладаг бөгөөд үүнийг түшиглэн гадаад дотоодын хөрөнгө оруулагчдийг татах, баруун бүсийн хөгжилд өндөр ач холбогдолтой стратегийн чухал газар гэж үзэж байв.
8. Баян-Өлгий аймгийн түүх, А.Минис. УБ, 1969.

### **3. Буянт тэжээлийн аж ахуй**

1. Ховд аймгийн Буянт сум.
2. 1922 онд анх сангийн тариалан нэртэйгээр байгуулагдсан. 1922 онд Манжийн үеийн Ховдын албан тарианы ардуудыг язгуур хошуу нутагт нь буцаан захируулах гэсэнд зарим ядуу тариачин ардууд ачлага, уналга дутагдалтай байснаас идээшсэн газраа суулгаж өгөхийг хүссэн учир тэдгээр ардуудын хүсэлтийг ёсоор болгож Бэйс Жамсрангаар захируулан дангаар нь “Тариачин” хошуу болгосон нь одоогийн Буянт сумын өмнөх үеийнхэн байжээ.  
1931 онд Чандмань уулын аймгийг Ховд, Увс гэсэн хоёр аймаг болгосноор Ховд аймаг нь Буянт, Баянхайрхан гэх мэт 12 сумтай Мөнххайрхан, Үенч, Булган зэрэг тусгай хошуутайгаар байгуулагдахад Наранхайрхан уулын хошуунаас Буянт сумыг байгуулж Цагаанбургасанд төвлөрүүлж засаг захиргааны ажлыг анх явуулж эхэлсэн байна.  
1931-1932 онд Буянт сумын нутаг дэвсгэрт “Нэгтгэлийн улаан зам” Баянхайрхан, Сангийн тариалан гэх зэрэг хамтралууд байгуулагдан, хамтралын дэргэд намын үүрүүд ажиллаж байжээ. 1942 онд Буянт сумаас Дуут сумыг салган байгуулж 1952 онд Буянт сумын 10, 13-р багийг таван хороо болгож Жаргалант хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааг байгуулжээ. 1932 онд Буянтын “Нэгтгэлийн улаан зам” хэмээх хамтрал татан буугдсаны дараа Буянт сумын ард намын гишүүн Т.Дэрэм ахлагчтай мал аж ахуйн нөхөрлөлийн эвлэл байгуулагдан ажиллаж байгаад 1937 онд сумын анхны нэгдэл болж хожим нь 17 гэсэн улсын дугаартай тамга нээн ажиллаж эхэлснээс нутаг усандаа Буянтын 17-ийн нэгдэл гэж нэрлэгдсэн нь “Соёл” нэгдлийн эх үүсвэр болжээ.  
1957 онд Буянт сум Баатархайрхан, Буянт гэсэн 2 сум болон салж Баатархайрхан сум нь Жаргалант амьдрал, Улаан туг гэсэн нэгдлүүдтэй Жаргалант хотын ойролцоо Буянт голын хөвөөнд төвлөрчээ.  
Соёл нэгдэлд 1959 онд дээрх 2 нэгдэл нийлж 1960 он гэхэд байнгын 5 бригадтай ажиллаж байжээ. 1958 онд сум төвлөрч байсан Цагаан бургасанд

ус гарснаас цаашид барилга барих боломжгүй гэж сумын төвийг нүүлгэж аймгийн төвд суурьшуулжээ.

1978 оноос Тэжээлийн аж ахуй болгосон байна.

3. 1993 он.
4. БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1978 оны 307 дугаар тогтоолоор Буянт сумын ТАА, Эрдэм шинжилгээний станцын хамт төвлөрүүлэхээр шийдвэрлэсний дагуу 1979 оны 8 дугаар сард “Зургаагийн газар” нүүж байрлажээ. Буянт голын хөндий дагуу хуучин албан тарианы газар оршиж байв.
5. Н.Булгаа 1137 цн байцаа, Ж.Цэцгээ 455 цн манжин, Т.Эрбуян 376 цн даршны ургамал хураан авч улс, аймгийн дээд амжилт тогтоосон байна. Тэжээлийн аж ахуйн анхны даргаар С.Жамбалдорж, Т.Очир нар ажиллаж байжээ.
6. 1932 онд улаан буудай, овьёос зэрэг үр тариа 1100 га, вандуй 32 га, зүйл бүрийн ногоо 2 га бүгд 1134 га газар тариалж байсан.
7. 1716-1717 он Манжийн хаан Энх-Амгалангаас Ховд голын дагуу будаа тарианы суурин байгуулах зарлиг гаргасан. Үүнийг биелүүлэхийн тул цэргийн албыг гүйцэтгэгч 400 гэр бүл, хятад 100 гэр бүлийг тариалангийн ажилд дайчлан 872 шар, бусад зүйлсийн хамтаар анх байгуулагдсан. 1923 онд тэдгээр тариалж байсан сайн газар, шуудууг ашиглах зорилгоор Ховдын сангийн тариалан нэртэйгээр сэргээн тариулж эхэлсэн. 1939 онд Ерөнхий сайдын тушаалаар Ховдын станцад нэгтгэгдэж, 1943 онд дахин САА болсон.
8. Ховдын хураангуй түүх. Д.Гонгор, УБ, 1964.

#### **4. Улаантолгой**

1. Увс аймгийн Улаангом.
2. 1979 оноос эхлэж чацаргана тариалж эхэлжээ.
3. 1990-ээд оны эхээр Чацаргана ХК болон хувьчлагджээ.
4. Огзомын хөтөлийн урд хэсэг орших Улаантолгой хэмээх жижиг толгойн дэргэд байгуулжээ.
5. Сангийн аж ахуйн даргаар С.Дэчинпил, Тувааны Цэвээн нарын хүмүүс /1980-1983/ онд ажиллаж байжээ. Ерөнхий агрономичоор Халзангийн Цэвгээ ажиллаж Улаантолгойн сангийн аж ахуйг ихэд хөгжүүлжээ.
6. 1979-оноос чацарган тариалж эхлэсэн боловч 1983 он хүртэл огт жимс хураагаагүй байна. 1984 онд анх удаа 6 тн, 1985 онд 36тн, 1986 онд 86тн гэх мэтээр өсч дээд тал нь жилдээ чацарганы 360 тн жимс, ихээхэн хэмжээний төмс хүнсний ногоо, хадлан, үр тариа авдаг болжээ. Энэ үед чацаргана тариалсан талбай 360 га хүрч 500 га-ийн услалтын системийн 475 га-г ашиглаж байжээ. Хамгийн ихдээ 260 хүн ажиллаж байжээ.

7. Механик бригадын дарга Т.Дүгэрсүрэн, Ю.Галсан, механик Х.Рэнцэнсамбуу, тоо бүртгэгч М.Жигмэд, Ж.Жигмэд, цэцэрлэгчин Р.Жаргал, Д.Нарантуяа, М.Оролгоор, М.Янжиндулам, Ц.Цэцэгбал, Б.Түмэнбаяр, тракторчин Р.Буна, Ц.Өлзийтогтох, А.Мягмар, Ж.Хүүхэнжав зэрэг хүмүүс онцгой сайн ажиллаж байжээ.  
1989 онд Б.Лааган, Б.Бат-Очир, Д.Янжив, Ж.Гээзэн нарын 4 хүнд БНМАУ-ын төрийн шагнал, С.Дэчинпил, хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон, Д.Волоож “Алтан гадас” одонгоор шагнагдаж байжээ.
8. Миний хайртай Улаангом, Н.Сүхбаатар ба бусад, УБ, 2006.  
Увс аймгийн газарзүйн нэрийн товч толь бичиг, Р.Адъяа, УБ, 2003.

## 5. Хархираа

1. Увс аймгийн Тариалан сум.
2. 1979 онд тэжээлийн аж ахуйн ашиглалтын өмнөх захиалагчийн захиргаа гэж байгуулагдсан. 1982 онд Хархираа тэжээлийн аж ахуйг байгуулжээ.
3. 1992 он.
4. Хархираа Түргэний голын хөвөөг дагуулан байгуулсан.
- 5.
6. Тэжээлийн аж ахуй нь малын тэжээл үйлдвэрлэх үндсэн чиглэлтэй. 3000 гаруй га эргэлтийн талбайд жил тутам 2000-2500 га-д үр тариа, малын тэжээл тариалдаг. Мөн жилдээ 7000-1100 тонн холимог хорголжин тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай тэжээлийн үйлдвэр ажиллаж байсан.  
Талбайн бүх усалгааг орчин үеийн техникээр хийж байсан. Усыг Хархираагийн голд барьсан толгойн барилгад цуглуулах буюу мөсийг хайлуулж 250-1000 мм-ийн диаметртэй, газрын хөрсөнд 2 метрийн бороожуулагч машинаар усалгаа хийдэг. Уг бороожуулагч 54 цагт 1 удаа бүтэн эргэлт хийхдээ 72-92 га талбайг усална.
7. Энэ тэжээлийн аж ахуйд гол төлөв нутгийн иргэд ажиллаж байсан бөгөөд Дөрвөд, Хотон, Баяд зэрэг ястан голлон ажиллаж амьдарцгаадаг байна. Хархираа тэжээлийн аж ахуй нь одоо Увс аймгийн Тариалан сумын нэгэн баг болжээ. Уламжлалт ахуй, соёл, зан заншлаараа Монгол улсын хэмжээнд нэн өвөрмөцөд тооцогдох хотон хэмээх үндэсний цөөнх Тариалан сумын нийт хүн амын 85.6%-ийг эзэлдэг, хотон ястны өлгий нутаг юм. Түүхэнд тэмдэглэснээр Ойрадын Галдан Бошигт тариалангийн ажил эрхлүүлэх зорилгоор Дорнод Туркестаны Хотан хотоос 200 гаруй өрхийг нүүлгэж ирүүлснээр монгол дахь хотон ястан үүсэн бүрэлдсэн тухай түүхийн ном сударт тэмдэглэсэн.
8. Увс аймгийн газарзүйн нэрийн товч толь бичиг, Р.Адъяа, УБ, 2003.  
Увс аймгийн толь. А.Нямаа. УБ, 1999.

## 6. Тэсийн тэжээлийн аж ахуй

1. Увс аймгийн Тэс сум.
2. 1975 онд Тэжээлийн аж ахуй байгуулагдсан.
3. 1992 онд татан буугдсан.
4. Огзомын хөтөлийн урд хэсэгт орших Улаантолгой хэмээх жижиг толгойн дэргэд байгуулжээ.
5. Тэс ТАА-д нийт хэд хэдэн хүн даргаар нь ажилласнаас Дашийн Гомбосүрэн гэдэг хүн уг албыг 15 жил хашихдаа сум орныг хөгжүүлэхэд ихээхэн хүчин зүтгэл гаргасан юм.
- 6.
7. Тэс суманд сүүлийн жилүүдэд Дундбух, Цагаан бураа, шар хотгор зэрэг газарт төмс хүнсний ногоо тарьж байна
8. Увс аймгийн газарзүйн нэрийн товч толь бичиг, Р.Адъяа, УБ, 2003.  
Увс аймгийн толь, А.Нямаа, УБ, 1999.

## 7. Баруунтуруун

1. Увс аймгийн Баруунтуруун сум.
2. 1930 онд БНМАУ-ын VI их хурлаас САА анх байгуулагдсан. 1931-1932 оны үед зүүнтний алдаа завхарлын үед САА-д олноороо алдагдалтай ажилласан учир 1933 онд татан буужээ. МАХН-ын Төв Хороо, СнЗ-ийн 1943 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 30/36 тогтоолоор тус станцыг үр тариа, мал аж ахуй эрхлэх чиглэлээр Баруунтурууны сангийн аж ахуй болгон байгуулжээ.  
Түүний 800-гаад адуу, 60 гаруй тэмээ, 100 гаруй үхэр, 1000 гаруй хонийг тус аж ахуйд шилжүүлэн өгснөөр мал аж ахуй эрхлэх үндэс тавигдаж 1938 оны намар САА-н төв нь одоогийн сумын төвд суурьшиж ажлаа явуулж эхэлжээ.  
1959 оны 6 дугаар сарын 15 нд БНМАУ-ын АИХ-ын зарлигаар Баруунтуруун сумыг Ханхөхий уулын ар бэлд байгуулжээ. Улсын САА байгуулагдсан 1943-1959 он хүртэл засаг захиргааны хувьд одоогийн Цагаанхайрхан суманд харъяалагдаж Туруун сум нэртэйгээр явж байжээ.
- 3.
4. Увс аймгийн Баруунтуруун голын хөвөөнд.
5. 1959 онд сум-САА болж даргаар нь О.Уламбаярлах ажиллажээ. Мөн САА-гаас Монгол Улсын хөдөлмөрийн баатар Д.Батсуурь, Ц.Сандуйжав, Д.Цэрэн, С.Эрдэнээ нар төрөн гарч, Н.Мэндбаяр, Н.Цэдэв, Б.Коля, Б.Дожоо, Н.Лхамсүрэн, Д.Чулуун нарын зэрэг 30 хүн, 15 тасаг, бригад, салаа, үтрэм улсын ургацын аварга цол хүртэж, мөнгөн шагнал, диплом авчээ.
6. САА-ын идэвхтэй үйл ажиллагааны жилүүдэд, жилд 5000-7000 хонийг

зохиомлоор хээлтүүлж, чөлөөт хээлтүүлгийг бүрэн зогсоосон байна.

1990 онд тус САА 119.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, 132 трактор, 96 камбайн, 1239 ХАА-н техник, 51 автомашин, 22.8 мянган га эргэлтийн талбайтай, жилд 30 гаруй мянган га-д үр тариа, малын тэжээл, төмс хүнсний ногоо тариалж, Улаангомын гурилын үйлдвэрийг тариагаар хангаж, жилдээ 17-20 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байв. 1990 оноос Баруун ба Зүүнтурууны гэсэн 2 САА, газар тариалан эрхлэх 6 хувьцаат компани, 7 ХЭАА болон задарсан байна. Тус сумын иргэд үйлдвэрлэл эрхэлж ирсэн түүхэн уламжлалтай, тариаланд тохиромжтой үржил шимтэй газар нутагтай. 2006 онд 1570 га-д тариалалт хийсний 260 орчим га-д нь үр тариа, 20 га-д нь төмс, 10 га-д нь хүнсний ногоо, 1285 га-д нь малын тэжээлийн таримал ургамал тариалжээ. Газар тариалангийн үйлдвэрлэлийг аж ахуйн 4 нэгж, 5 байгууллага, 710 өрх эрхэлж байна. Сүүлийн жилүүдэд үр тариа, төмс, хүнсний ногооны тариалалт бага зэрэг буурч, харин усалгаатай нөхцөлд ажилладаг.

7. Газар тариалан, МАА-н үйлдвэрлэл эрхэлж байв. 1940-1950-иад оноос тус САА эдийн засаг, техникийн хувьд бэхжсэн байна. 1945 оноос үйл ажиллагаа нь тодорхой чиглэлд орж, Баяд угсааны хонь үржүүлэх аж ахуй болсон.

1929 онд Улаансан хамтрал, 1937 онд өвс хадах морин станц, 1941 онд МАХН-ын үүр, 1942 онд гар үйлдвэрийн тасаг, 1943 онд улсын сангийн аж ахуй, 1946 оноос хүн эмнэлэг, аптека, 1947 онд бага сургууль, 1952 онд хүүхдийн цэцэрлэг, холбоо, 1953 онд мал эмнэлэг, 1955 онд цагдаагийн тасаг, 1956 онд ус, цаг уурын станц, 1957 онд 10 жилийн сургууль, дизель цахилгаан станц, шатахуун түгээх станц, 1961 онд соёлын төв, 1982 онд ахуй үйлчилгээний төв, 1983 онд хорголжин тэжээлийн үйлдвэр, 1983 онд АТС, экран зурагтын станц, 1986 онд 75 тракторын засварын газар, 1990 онд 2000 га-гийн услалтын систем, 8 сая куб метр багтаамжтай хиймэл нуур, Зүүнтурууны САА, 1995 онд цагдаагийн тасаг, 1997 онд 100 квт усан цахилгаан станц, 1998 онд нисэх буудал, сансрын Висат систем, 1998 онд Хилийн цэргийн комендатур, 2000 онд хилийн цэргийн хороо, 2002 онд Жанрайсаг дацан, 1997 онд нисэх буудал /улсын анхны хувийн нисэх буудал/, 2002 онд нисэх буудлын шинэ барилга, сансрын холбоо тус тус байгуулагдан ажиллаж байна.

8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдагва, УБ, 1998.  
Увс аймгийн тайлбар толь, А.Нямаа, УБ, 1999.

## **8. Тэсийн тэжээлийн аж ахуй**

1. Завхан аймгийн Тэс сум.

2. 1969 онд байгуулагдсан.
3. 1992 онд хувьчлагдсан.
4. Тэсийн голын хөвөө Зүр уул.
5. Нэгдлийн даргаар Д.Рэнчин 1956-1957 (“Мандах” нэгдэл), Д.Балгансүрэн 1956-1957 (“Жаргалант-Амьдрал” нэгдэл), И.Дамдинбазар 1956-1959 (“Дэлгэрэх” нэгдэл), Д.Гүнчин 1958-1959 (“Жаргалант-Амьдрал” нэгдэл), Х.Дагийнаа 1959-1964, Д.Пүрэвсүрэн 1964-1965, С.Зунрий 1965-1968, Ц.Гэцэнпилжээ 1968-1989, Д.Дагвадорж 1989-1991, Ж.Мөнхбаатар 1991 онд тус тус ажиллаж байжээ

Шинэ тутам байгуулагдсан тэжээлийн аж ахуйн даргаар А.Балчин ажиллаж байжээ.

Алтангэрэлийн Бэгзсүрэн Тэсийн тэжээлийн аж ахуй болон “Дэлгэрэх” нэгдлийн малчин 1967 онд 132 үнээнээс 132 тугал бойжуулан “БНМАУ-ын аварга малчин” цол энгэрийн тэмдэгээр шагнагдаж байжээ.

6. 1963 онд байгуулагдсан МААМС-ийн суурин дээр түшиглэн тариалангийн үйлдвэрлэл эрхлэн жилд 4000 тонн орчим таримал тэжээл, 3000 тонн орчим байгалийн хадлан, 300 тонн гаруй холимог тэжээл үйлдвэрлэн нэгдлийнхээ малын хэрэгцээт тэжээлийг өөрсдийн нөөц бололцоон дээр тулгуурлан үйлдвэрлэхийн дээр мал сүргээ хонин толгойд шилжүүлснээр 273,1 мянган толгой хүртэл өсгөн, туслах аж ахуйдаа 70 гаруй гахай үржүүлж байв. Энэхүү нэгдлийн мал аж ахуйд 800, туслах үйлдвэрт 50, газар тариаланд 40 гаруй хүн ажиллаж байжээ.

1974 онд Тэс сумын Дэлгэрэх нэгдлийг татан буулгаж Баян-Уул сумын Жаргалант амьдрал нэгдэлд нийлүүлж “Дэлгэрэх-Амьдрал” гэж нэрлэн Баян-Уул суманд харъяалуулсан байна.

Улмаар СнЗ-ийн 1975 оны 7 сарын 18-ны өдрийн 336-р тогтоолоор Тэсийн тэжээлийн аж ахуйд адуу 100, хонь 459,1, ямаа 2409 бүгд 7100 малыг Баянтэс (Баян-Уул) сумын “Дэлгэрэх амьдрал” нэгдлээс шилжүүлсэн.

Тэжээлийн аж ахуйн тариалалтын үеүдэд жилд 4000 тонн орчим таримал тэжээл, 3000 тонн орчим байгалийн хадлан, 300 тонн гаруй холимог тэжээл үйлдвэрлэн малын хэрэгцээт тэжээл бэлтгэж байв.

1990-ээд оны эхэн үе гэхэд суудлын автомашин 2, ачааны автомашин 10, гинжит, дугуйт трактор, комбайн 20, 200 гаруй га талбай услах хүчин чадалтай инженерийн услалтын систем, 20-н тоннын үрийн агуулах үтрэм, 30-н тоннын мөсөн зоорь, 20 ортой зочид буудал, таван хүний халуун ус, соёлын өргөө, дархан, мужаан, элдүүр, хиам, арвайн гурилын цех, оёдлын тасаг бүхий томоохон нэгдэл болж чадсан байна. Мөн 8-н жилийн сургууль, хүний их эмчийн салбар, хүүхдийн цэцэрлэг, хүүхэд саатуулах газар, мал эмнэлэгийн салбар, ахуйн үйлчилгээний төв, уурын зуух, 630 квт хүчин чадалтай цахилгаан станц, 2000 тонн ногоон тэжээл



хатаах саравч, 2000 өндөглөгчтэй тахианы байр, 100 тонн хүнсний ногооны агуулах зэрэг байгууламжууд баригдаж эхэлсэн байна. Улмаар газар тариалангийн зэрэгцээ мал аж ахуйн Аргалант бригадыг байгуулан 10001 толгой малтайгаар үйл ажиллагааг нь эхлүүлсэн байна.

7. Хуучнаар ЗХУ-ын тусламжтайгаар Тэсийн тэжээлийн аж ахуй байгуулагдаж тэнд хүн ам олноор суурьшин сургууль, эмнэлэг, барилга орон сууц баригдаж эхэлжээ. 1974 онд Тэс сумыг татан булгаж Тэсийн хороог байгуулсан байна. Үр тариа, тэжээл тарихад тохиромжтой Тэсийн голын өмнөд хөвөөнд хуучны МААМС-ын түшиглүүлэн байгуулсан.

Гэвч хоёр жилийн дараа 1976 онд БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн 138-р зарилгаар Тэсийн хороог өөрчилж Тэс сумыг дахин байгуулжээ. Энэ үед Тэсийн хороо 600 өрх, 3000 шахам хүн ам, 13,0 мянган малтай байсан ажээ. Хангайн бүс нутгийн эрс тэс уур амьсгалтай энэ бүс нутгийн тухайд малаа өсгөн, түүний зэрэгцээ улсын хэмжээний уралдаанд удаа дараа шалгарч байв. Тухайлбал, 1986 онд ажлаараа улсын хэмжээнд шалгаран төв дөрвөн байгууллагын шилжин явах туг, диплом, мөнгөн шагнал хүртэж байсан бол, цэцгийн тосны үйлдвэрлэл, малын тэжээлийн бэлтгэл, бүртгэл тооцооны чиглэлээр улсын уралдаанд удаа дараа шалгарч байжээ.

8. Завхан нутгаас төрсөн хөдөө аж ахуйн салбарын алдартнууд (Завхан судлал I), Д.Баярсайхан, УБ, 2007.

## **9. Гуулин хороо**

1. Говь-Алтай аймгийн Дэлгэр сум.
2. 1962 он.
3. Монгол улсын их хурлын 1990 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 36 дугаар тогтоолоор Гуулин хороог татан буулгаж Дэлгэр суманд нэгтгэсэн байна.
4. Дэлгэр уулын өвөрт
5. Ц.Лоохууз анх байгуулж ажиллаж байв.
6. Гуулингийн талд 6000 га атар газрыг эзэмших усан системийн усжуулалтын эхний ээлжийн ажил бүрэн дуусч 1965 онд 314 га талбайд үр тариа, хүнсний ногоо, малын тэжээл тарьж байлаа. Мөн мод үржүүлгийн газрыг байгуулан Говь-Алтай аймгийн хэмжээнд тарьсан мод, ургамлын үрээр хангадаг байжээ.
7. Говь-Алтай аймагт 1962 онд усжуулах контор байгуулагдсан. Үүнээс хойш Гуулингийн талд орчин үеийн тоног төхөөрөмжтэй суваг баригдаж эзүүд олон мянган га газар усжуулагджээ.  
СнЗ-ын 1974 оны 5 дугаар сарын 7 ны өдрийн тогтоолоор Говь-Алтай аймаг, Баянхонгор аймгийн хилийн залгаа аймаг дундын отрын нөөц нутаг байгуулж, Гуулин Тэжээлийн Аж ахуйд харъяалуулав.  
Хөрсний салхины эвдрэлээс хамгаалах ой зурвас байгуулах ажлыг

нэвтрүүлж байсан.

8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдагва, УБ,1998.  
Говь-Алтай аймгийн түүх, В.Бүнчин ба Ч.Сонгино, Алтай, 1986.

## 10. Байдраг

1. Баянхонгор аймгийн Жаргалант сум.
2. 1956 онд байгуулагдсан.
3. 1991он.
4. Төв нь Байдраг голын хөвөөнд байгуулагдсан.
- 5.
6. МАА сууриудад 600 эм хонины багтаамжтай, нэг бүр нь 340 мянган төгрөгний үнэ бүхий 50 хашаа, эр сувай малын хашаа 24, усан сан 80, өрөмдмөл худаг барьж байгуулжээ. Чамар хэмээн нэрлэгдэж байсан сайн чанарын хонины хувьд өөрчлөлт гарч, 1983 оны 3 сард Байдраг үүлдэр бий болсон.  
1986 оны мэдээгээр Байдраг үүлдэрийн хонь 40 гаруй мянга болж, ширүүвтэр ноосны чиглэлээр хонь үржүүлдэг бүсийн аймгуудад энэ хониор сайжруулсан эрлийз хоньтой болжээ.
7. 1956 оны хавар Завхан аймгийн Алдархаан сумын нутгаас хонь үржүүлэх чиглэлийн сангийн аж ахуй, Баянхонгор аймагт шилжин ирж, Байдраг голын хөндийд төвлөрөх болсноор улсын аж ахуйн суурь тавигдав.  
1961 онд Байдрагийн САА өвс хадах, үржил, зохиомол хээлтүүллэгийн станц болж өөрчлөгдөв.  
Улсаас малын ашиг шим, үүлдэр угсааг сайжруулж, сайн чанарын ширүүвтэр ноос “Чамар” хонь өсгөн үржүүлэх чиглэлээр 1953 онд Байдрагын САА-г байгуулсан. Энэ САА-д ЗХУ-ын тусламжтайгаар иж бүрэн тохижуулан 70 сая төгрөгийн барилга байгууламж барьсан байна.  
Тус САА-д 10 жилийн сургууль, ясли, цэцэрлэг, жилдээ 25 трактор засах хүчин чадалтай засварын газар, 400 квт-ын эрчим хүчийг гаргах цахилгаан станц, 60 айлын сууц, сум дундын их эмчийн салбартай байна.  
Мөн МАА-н 3 тасгийн төвд улаан булан, контор, цахилгаан станц, халуун усны газар, цахилгаан мотороор тоноглогдсон эмчилгээ тэжээлийн цэгийн газар, мал угаалгын цэг зэрэг чухал барилгууд баригджээ.
8. БНМАУ-ын Баянхонгор аймгийн түүхийн, Д.Рэгсүрэн, Баянхонгор, 1990.

## 11. Төвшрүүлэх

1. Архангай аймгийн Төвшрүүлэх сум.
2. 1923 онд ардын засгийн тогтоолоор Нутаг дэвсгэрийн шинэчилсэн хуваарь хийж, хошуудын хуучин нэрийг халж Цэцэрлэг мандал уулын

аймаг байгуулсан Сайн Ноён Хан аймгийн чуулганыг одоогийн Цэнхэр сумын нутаг Төвшрүүлэх сумын нутаг байсан Цэцэрлэг голын баруун сав Мандал толгойн орчимд хийдэг болсноор Цэцэрлэг мандал аймаг гэдэг нэр анх үүссэн. 1943 оны 4 сард Төвшрүүлэх сумын машинаар өвс хадах станцыг Сангийн аж ахуй болгосон. Энэ үеэс САА-нуудыг анх удаа даргатай болгосон байна. Үхрийн шинэ үүлдэр гаргахын тулд Архангайн Түвшрүүлэхийн САА-г үхэр үржүүлэх аж ахуй болгон өөрчлөх зэрэг арга хэмжээнүүд авахаар төлөвлөсөн байна.

3. 1990 онд татан бугдаж Төвшрүүлэх сум САА нь “Хэцийн цуурай” захирал нь Н.Нарантуяа, “Бага хангай” захирал нь Б.Жавхлан, “Жинс” захирал нь Г.Цэрэнбат, “Алтан салаа” захирал нь Б.Нямсүрэн зэрэг ХХК болон зохион байгуулагдаад байна.
4. Төвшрүүлэх гэдэг нь нэр олдохгүй, төвширөх гэсэн үгнээс үүсжээ.
5. 1960 онд тус САА-н механикч Туваан Архангай аймгаас анхны БНМАУ-ын хөдөлмөрийн баатар цол хүртжээ.
6. Энэ үеийн газар тариалангийн ажлыг техникээр гүйцэтгэж ирснийг 1943оны хаврын тариалангийн ажлаас үзэж болно. Архангай (Одоогийн Түвшрүүлэх) бүх тариалсан талбай (га-гаар) 1100, техникээр гүйцэтгэсэн нь 61,8% байна. 1943-1947 онд машинаар өвс хадах, морин станцын тоо дөрөв дахин, хадаж авсан өвс хоёр дахин, мал арван ёс дахин өсчээ. Сычөв үүлдрийн тугал анх гарахдаа 39-42 кг, 6 сартайдаа 171 кг, 12 сартайдаа 314 кг амьдын жинтэй болдог байжээ.

Улс орон даяар газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлж гурил, малын тэжээлийн асуудлыг дотооддоо үйлдвэрлэх зорилгоор Улс төрийн товчооны 40 дүгээр тогтоолоор байгуулсан ууган 5 аж ахуйн нэг нь Төвшрүүлэхийн сангийн аж ахуй байлаа. Төвшрүүлэх сум нь Улаанбаатар хотоос 464 км, Цэцэрлэг хотоос 45 км зайд, далайн түвшнөөс дээш 1900 м өргөгдсөн, ойт хээрийн бүсийн үзэсгэлэнт нутагт оршино. Төв нь “Таван булаг” нэртэй. Өөрийн аймгийн Хотонт, Батцэнгэл, Цэнхэр, Өгийнуур сумтай хиллэдэг. Нутаг дэвсгэр нь 1,2 мянган ам км буюу 122283 га газар нутагтай, үүний 14 хувийг ус, ой эзэлдэг, 3410 хүн амтай, 894 өрхтэй. Тус сангийн аж ахуй нь ид хөгжиж байхдаа газар тариалангийн 18 мянган га эргэлтийн талбай, 2,8 мянган га хадлангийн, бэлчээрийн 89,8 га талбайд үйлдвэрлэл эрхлэн үр тарианы 2, хадлан бэлтгэлийн 1 тасаг, МАА-н 3 бригад зохион байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байсан. Үндсэн үйлдвэрлэл нь МАА, газар тариалан хослон эрхэлж байв. 2008 оны малын тооллогоор нийт 108900 толгой малтай, үүний 9778 адуу, 6186 үхэр, 47973 хонь, 44963 ямаатай болжээ. Газар тариалангийн үйлдвэр явуулахын тулд сумын 120 тракторын засварын газар, 2 тасагт 20 тракторын засварын цех, механикжсан үтрэм 2, мөн 1,1 сая квт эрчим хүч гаргах дезиль станц, 3

уурын зуух, жилд 500 тонн багсармал гэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай хорголжин гэжээлийн үйлдвэр, модны үйлдвэр, гэр ахуйн үйлчилгээний цех зэрэг нэгжтэй гинжин трактор 38, дугуйт трактор 85, комбайн 40, автомашин 39-тэй үйлдвэр үйлчилгээ эрхэлж байв.

7. Төвшрүүлэх сумын үндсэн суурийг тавьсан хадлангийн морин станц гэдэг нь 20 гаруй морин хадуур, мөн тэр хэмжээний тармуур, бас өвс боогчтой ирж Ар хүйтний Хүйтэн нуурын чанх хойно Дагинын толгойн ард орших “Хонх тал” гэдэг газар 10 гаруй гэр, майхан барьж суурьшиж буудалласан билээ. Энэ нь орос улсаас Маршал Чойбалсанд бэлэглэсэн 10 морин станцын нэг нь байлаа. Нэг сар хэртэй болоод тэндээсээ нүүж Хөх сүмийн “Улаан чулуу” буюу “Эрдэнэ толгой”-н хавьд суурших болжээ.

1952 онд үхрийн үүлдэр хөгжүүлэх чиглэлтэй болгон өөрчилсөн байна.

1953 онд мах сүүний чиглэлийн сычөв үүлдрийн охин бяруу 20, эр шүдлэн бух 29 авчирч үржүүлснээр 117 цэвэр сычөв үхэртэй болжээ.

1960 онд 9904 га атар газар тариалах ажлыг амжилттай дуусгаж, 2497 га газар тариалж бүх тариагаа ангилан хурааж, га тутмаас 21,8 цн үр тариа хураан авсны дотор улаан буудай га тутмаас 25 цн авчээ. Энэ нь тухайн үеийн Монголын хувьд өндөр үзүүлэлт байв.

8. Архангай аймгийн түүх, Д.Рэгсүрэн ба А.Балжинням, Цэцэрлэг, 1973.  
Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдагва, УБ, 1998.  
БНМАУ-ын сангийн аж ахуйнууд, Д.Мандалсүрэн, УБ, 1969.

## 12. Тариалан

1. Хөвсгөл аймгийн Тариалан сум.
2. 1943 онд СнЗ-ын зөвлөлийн тогтоолоор САА болон өргөжжээ.
3. 1992 онд хувьд гарч одоог хүртэл үйл ажиллагаагаа явуулж байна. Алтан дуулга ХХК ны захирал Доржпүрэв ажилладаг.
- 4.
5. 1970 онд Ж.Содов нарын олон сайчууд төрөн гарсан.
6. Нийт 3,431 км<sup>2</sup> газар нутгийн 1,582 км<sup>2</sup> нь бэлчээр, 167 км<sup>2</sup> нь тариалангийн талбай (Хөвсгөл аймгийн нийт тариалангийн талбайн 74%) болно.
7. Тариалан сум нь Хөвсгөл аймгийн газар тариалангийн нөөцийн ихэнх хувийг хангадаг Сэлэнгэ мөрний хойд хөвөөнд орших сум юм.
8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдагва, УБ, 1998.  
Хөвсгөл аймгийн лавлах толь, М.Нямаа, УБ, 2001, х.129.

## 13. Магсаржав

1. Булган аймгийн Хутаг-Өндөр сум.

2. 1977 оны 9 дүгээр сар.
3. 1992 он.
4. Хутаг-Өндөр сумын нутагт мэндэлсэн Монголын тусгаар тогтнолын нэрт зүтгэлтэн, цэргийн яамны сайд Хатанбаатар Магсаржавын нэрэмжит болгосон юм.
- 5.
6. Уг САА нь 1990 оны байдлаар 21600 га эргэлтийн талбайтай, жилд дунджаар 17150 тн үр тариа хураан авч улсад 10000 тонныг тушааж байв. Улсын фондод 3000 тн өвс жилдээ бэлтгэдэг том САА байсан.
7. Газар тариалан үр тарианы чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. 10 орчим хүрээ хийд энэ нутагт байсан. Алаг өвс, алирс, шинэс, хус, хуш, ногоон хөвд, сөөг, ширэнгэ, гацуур бүхий баялаг ургамалтай сум.
8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдавга, УБ, 1998.

#### **14. Хархорин**

1. Өвөрхангай аймгийн Хархорин сум.
2. 1956 оны 04 сарын 27-нд БНМАУ-ын СнЗ-ийн 197-р тогтоолоор.
3. 1992 он.
4. Монголын эртний нийслэл Хархорумын нэртэй холбоотой.
5. Ерөнхий механикч БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар, гавьяат механикжуулагч Ц.Шатар ажиллаж байлаа.  
Сум, САА-н дарга АИХ депутат Л.Гомбосүрэн. дарга нар С.Пүрвээ, З.Цоодол, орлогч дарга Очир.  
Сайн малчин Д.Дорж.
6. Тус сум, САА 233.0 мянган га нутагтай үүний 10 хувийг тариалангийн үржил шимт хөрс, 83,4 хувийг хадлан бэлчээр, 3,6 хувь нь ой мод, уул ус эзэлдэг.  
1970-аад оноос эхлэн жилдээ 12-14 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 3-4,5 сая төгрөгийн ашигтай ажиллаж байна.
7. Газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг.  
1980 оны 3 дугаар сарын 14-ны өдрийн Монгол Ардын Хувьсгалт намын улс төрийн Товчооны 100 дугаар тогтоолоор Хархорины Сангийн аж ахуйн тэргүүн туршлагыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх шийдвэр гаргаж байжээ. Тус шийдвэрт алтан гадас одонт хархорины САА-н хамт олны дотроос хөдөлмөрийн баатар 4, гавьяат цолтон 4, улсын аврага 26 төрөн гарсан. Хархорины САА нь эдийн засгийн кабинет байгуулан түүндээ аж ахуйн дотоод тооцоо, анхан шатны бүртгэлийн нэвтрэлийг харуулсан самбар, үзүүлэн хийж тавьсны дээр төлөвлөлт, эдийн засгийн урамшууллын шинэ системээр ажилласны үр дүнг аж ахуйн салбар, нэгжүүдээр гаргаж эдийн

засгийн сургалт, сурталчилгааны ажилд ашиглаж байна. Мэргэжлийн боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулж, тэдний мэдлэг, боловсрол, ажлын арга барилыг дээшлүүлэхэд онцгой анхаарч ажилладагаас мэргэжилтэнүүд ажил дээрээ өсөж, тэдний хариуцлага дээшилжээ. Мэргэжилтнүүдийг 5 жилийн болон бүтээлч төлөвлөгөөтэй ажиллуулан ажлын тайланг нь намын үүр, хорооны товчоо, сумын хурлаар хэлэлцүүлж тогтмол үнэлэлт дүгнэлт өгдөг байна. Жил бүр хаврын тариалалт, намрын тариа хураалтанд гарахын өмнө залуу техникчдийн эзэмшиж байгаа трактор, комбайныг туршлагатай хүмүүсээр шалгуулан зөвлөгөө өгүүлдэг байна. Аж ахуйн тодорхой зорилтыг олон түмэнд сурталчилах, хэрэгжүүлэх ажлын уялдаа холбоог сайржуулах, хамт олны идэвх санаачилгыг өрнүүлэхийн тулд ургац хураалтын нээлтийн өдөрлөг, төлчин, саальчин эмэгтэйчүүдийн хөдөлмөр, соёлын чуулга, малчдын төрөлжсөн зөвлөгөөн зэрэг бүх нийтийг хамарсан болон хэлбэрийн ажлыг зохион байгуулдаг байжээ.

8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдагва, УБ, 1998.  
Алтан гадас одонт Хархорины САА, Д.Нүрэнзэд ба Т.Рэнзэн, Арвайхээр, 1976.

## 15. Сансар

1. Булган аймгийн Рашаант сум.
2. 1982 онд Булган аймгийн Гурванбулаг, Дашинчилэн, Төв аймгийн Эрдэнэсант зэрэг сумдын захаас оруулан байгуулагдсан.
3. 1992 онд хувьчилагдсан.
4. Сансар уулын зүүн урд хэсэгт.
- 5.
6. 2007 оны байдлаар 82405 малтайгаас тэмээ 33, адлуу 5238, үхэр 2590, хонь 39936, ямаа 35218 тоологдсон ба 20 га төмс хүнсний ногоо тариалсан байна.
7. Монгол улсын анхны сансарын нисгэгч Монгол улсын баатар, Ж.Гүррагчаад зориулан ЗХУ-ын тусламжаар байгуулагдсан.
8. Булган аймгийн бага нэвтэрхий толь, Ж.Болдбаатарба Ц.Пүрэвсүрэн, УБ, 2008.

## 16. Эрдэнэсант

1. Төв аймгийн Эрдэнэсант сум.
2. 1971 онд ЗХУ-ын (хуучнаар) тусламжаар Тэжээлийн аж ахуй болгон өргөжүүлж, иж бүрэн байгуулжээ.
3. 1990-ээд оноос хувьд шилжин өдөөг хүртэл үр тариа тариалалт үргэлжилж

Буянт төв, Хоргохайрхан зэрэг компани болон ажиллаж байна.

4. Эрдэнэсант сумын төвийг түшиглүүлэн байгуулжээ.

5. 1. Өвс хадах морин станцын даргаар:

- Хоролжавын Чой
- Пэлжээгийн Цэвэгдорж
- Пүрэвийн Буяравжих
- Гомбын Дэмбэрэл
- Шагдарын Нэмэхбаяр

2. МААМС-ын даргаар

- Б.Нацаг
- Д.Чулуун
- О.Дагва
- Д.Мишигдорж
- Р.Дондогжав

3. Тэжээлийн аж ахуйн даргаар

- Содномдоржийн Дамдинсүрэн
- Бадамжавын Бямбажав
- Жуудайн Сүрэнхорлоо

6. Тус тэжээлийн аж ахуй нь үр тарианы 4, хадлангийн 1, мал аж ахуйн 1 бригадтай, 15 морины хүчинд шилжүүлснээр 305 трактор, үр тарианы 60 гаруй комбани, ачааны ба тусгай зориулалттай 40 гаруй автомашин, ХАА-н төрөл бүрийн дүүжин ба чиргүүл машин, тоног төхөөрөмжөөр хангагдаж байв. 11,7 мянган тонн холимог тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай тэжээлийн үйлдвэр, 120 тракторт засвар үйлчилгээ хийдэг засварын газар, 2400 тонны багтаамжтай үр механикжсан агуулахууд, цагт 720 квт цахилгаан үйлдвэрлэх “ДГА-300”- маркийн цахилгаан станц, ажиллах хугацаандаа 2 сая кл дулаан гаргах хүчин чадалтай “Инерт- 6” маркын уурын зуух, халуун ус, талх нарийн боов үйлдвэрлэх хүнсний цех, нийтийн хоолны газар, 52 айлын тохилог сууц, 400 хүүхдийн сургуулийн барилга, тус бүр 25 ортой цэцэрлэг, ясли, аж ахуй захиргааны ба бригадын контор, улаан булан, цэвэр усан татуурга, бохир зайлуулах цэвэрлэх байгууламж баригдаж ашиглалтад оржээ.

7. Тэжээлийн аж ахуйд нийт 600 орчим хүн ажиллаж байснаас 200 орчим нь гадаад, дотоодын техник мэргэжлийн сургууль төгссөн мэргэжлийн механикчид ажиллаж байжээ. Тус тэжээлийн аж ахуйгаас Монгол Улсын төрийн шагнал Сүхбаатарын одонгоор 1, хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон 2, алтан гадас одонгоор 6, хөдөлмөрийн хүндэт медалиар 12, Атарчны алдар медалиар 10, Засгийн газрын хүндэт жуух бичгээр 26, V-VIII таван жилийн гавшгайчид 400 гаруй хүн тус тус шагнагдаж байжээ. 1975, 1977, 1983 онуудад Тэжээлийн үйлдвэрийн үйлдвэрлэсэн багсармал,

холимог тэжээл чанарын аттестатчиллаар өндөр үнэлэлт авч БНМАУ-ын СнЗ-ийн Үнэ стандартын улсын хорооны диплом, чанарын алтан медаль авч I ангийн бүтээгдэхүүн гэрчилгээ авсан байна.

8. Төв аймгийн Эрдэнсант сум, А.Бат-Очир, Л.Энхбаатар, УБ, 2000.

## 17. Баян нуур

1. Булган аймгийн Баяннуур сум.
2. 1979 онд байгуулагдсан.
3. 1990-ээд оны эхээр хувьчлагдсан.
4. 1962 онд татан буугдсан Баяннуур сумын төвийг түшиглэн байгуулжээ.
5. Тувааны Цэвээн тус САА-н даргаар 1983-1992 он хүртэл ажиллаж байв. Хадлангийн улсын аварга 10 орчим төрөн гарчээ.
6. 1979 онд ЗХУ-ын эдийн засгийн тусламжаар бүрэн механикжсан хадлангийн 8 салаатай байгуулагдаж, жилд улсын нөөцөд 100000 тонн өвс бэлтгэн, говийн аймгуудыг хангаж байв. Жилдээ 4-5 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, жил бүр улсын төлөвлөгөөг давуулан биелүүлж, эрчимтэй түргэн хөгжиж байгаад 1990-ээд оны эхээр хувьчлагджээ. Хүн амын хүнсний хангамжийг сайжруулах зорилтот программыг хэрэгжүүлэх зорилгоор чацаргана, үхрийн нүд, бэсрэг алим зэрэг жимс жимсгэнэ болон төмс, хүнсний ногоо нэлээд тариалж арвайн гурил, чангаамал талх, нарийн боов үйлдвэрлэж тахиа галуу үржүүлэн, хивсний цех байгуулан ажиллуулж байжээ.
7. Баяннуур тэжээлийн аж ахуйг байгуулагдсантай холбогдуулан 1980 оны 7 дугаар сарын 30-нд АИХТ-ийн 22-р зарлигаар Баяннуур сумыг байгуулж төвийг нь Өлзийт гэж нэрлэжээ.
8. Булган аймгийн (бага нэвтэрхий толь), Ж.Болдбаатар, Ц.Пүрэвсүрэн, УБ, 2008.

## 18. Ингэт толгой

1. Булган аймгийн Сэлэнгэ сум.
2. 1943 онд САА болон өргөжсөн.
3. 1992 онд хувьчлагдан хэд хэдэн хувиараа эрхлэх аж ахуй, компани болон задарсан.
4. Ингэт толгой.
5. Ерөнхий агрономч Б.Цэрэн 1971 онд БНМАУ-ын гавьяат агрономч болсон. Мал зүйч Дамдиндорж, Сүхбаатар, эрдэмтэн Р.Жавзмаа нарын удирдлагаар Монгол үхрийг Хасгийн цагаан толгойт үүлдэрээр махны чиглэлийн Сэлэнгэ үүлдрийг гаргаж авах ажлыг хийсэн. Хоньчин С. Гомбодорж ажлын арга туршилгаар 3 жил дарааллаж 160-170 хуц маллаж арчилгаа хамгаалалтыг 98-100 байлгаж бүх хуцнуудыг 100 хувь дундаас



дээш тарга хүчийг авахуулжээ. Дөрвөн жилийн дундажаар хуц нь хавар 60-70 кг, намар 75-80 кг жин тагаж байв.

6. Энэ үеийн газар тариалангийн ажлыг техникээр гүйцэтгэж ирснийг 1943оны хаврын тариалангийн ажлаас үзэж болно. Булган /Ингэт толгой/ бүх тариалсан талбай (га-гаар) 1502, техникээр гүйцэтгэсэн нь 25.9% байна. Анхдугаар таван жилд тус САА нэг хониноос 1.4 кг ноос, га тутмаас 11.8 центнер ургац авч чадсан нь тэр үеийн шинэ төлөв байдлыг харуулсан гарамгай сайхан жишээ болж байлаа.
7. 1937 онд ЗХУ-ын тусламжтайгаар өвс хадах машинт станцыг тус аймагт байгуулсан. Уг станц нь хожим Монгол Зөвлөлтийн найрамдлын нэрэмжит Ингэт толгойн САА болон өргөжсөн байна.1955 оны 2 дугаар сард МАХН-ын ТХ, СнЗ-ын хамтарсан хурлаас Ингэт толгойн САА-д үр тариаг хөгжүүлэхээр тогтоосон байна.
8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдагва, УБ, 1998.  
Булган аймгийн бага нэвтэрхий толь, Ж.Болдбаатар, Ц.Пүрэвсүрэн, УБ, 2008.

## **19. Улаантолгойн**

1. Орхон-уул аймгийн Жаргалант сум.
2. БНМАУ-ын СнЗ-ийн 1976 оны 249-р тогтоол гарч Эрдэнэт хотын хүн амыг төмс хүнсний ногоо, сүүгээр хангах Улаантолгой сангийн аж ахуйг байгуулан даргаар нь Р.Нямдоржийг томилсон байна.
3. 1992 онд хувьчлагдсан ба Орхон уул аймгийг байгуулахад нэг сум болон багтжээ.
- 4.
5. Анх Ингэттолгойн САА-гаас үр тарианы Улаантолгойн 4-р тасаг салахад 54 хүнтэй байжээ.

Үүнд:

тракторч 28

малчин 4

бригадын дарга 1

тасгийн дарга 1

тоо бүртгэгч 1

автомашины жолооч 1

үтрэмийн ба бусад ажилчид 18

1558 толгой хонь, 73 толгой үхэр, 11 толгой адуу байжээ.

Анхны даргаар Нямдорж, ерөнхий нягтлан бодогч Дондов, ерөнхий агрономич Баасанжав, ерөнхий инженер Авирмэд, эдийн засагч Мөнхжаргал нар ажиллаж байжээ.

6. Улаан толгойн тасгийг САА болгоход 4933617 төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байсан бөгөөд сүү хүнсний ногооны чиглэлээр бүтээгдэхүүн үйлдвэрлэл явуулахаар байгуулжээ.  
1970 онд 400 саалийн үнээ, үр тариа, хүнсний ногооны нийт талбай 7050 га байжээ.  
1977 онд САА-д 8800 цн улаан буудайн үр, 4000 цн төмсний үр, 700 цн овъёсны үр, шаардлагатай байгаагаас 6000 цн улаанбуудайн үр бэлэн хадагалагдаж байгаагаас өөр үр байхгүй байжээ.  
1978 оноос эхний ээлж нь ашиглалтанд орж ЗХУ-ын Латви, Литви, Эстониос сайн үүлдрийн 706 үхрийг 1978 оны 10-р сард ЗХУ-ын Наушик өртөөн дээр хүлээн авчээ. Үүний дараа 1200 тооны сүүний чиглэлийн үнээний фермийг ажиллуулж Эрдэнэт хотын хүн ардыг сүүгээр хангах болжээ.
7. 1976 онд Булган аймгийн Сэлэнгэ сумын Ингэттолгойн САА-н Улаантолгойн 4-р тасгийг таслан САА болгон өөрчилжээ.  
1976-1978 онуудад Улаантолгойн САА-н ашиглалтын өмнөх гүйцэтгэх захиргаа хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаад 1978 оны 01-р сарын 30-ны БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн 15-р зарлигаар Эрдэнэт хотын Жаргалант хороо болон зохион байгуулжээ. Энэ үед 501 айл өрх, 2200 хүн ам, 1800 толгой мал, 59,6 мянган га нутаг дэвсгэртэй байв.  
1980 оны 10-р сарын 24-нд Монгол-Зөвлөлтийн засгийн газрын комисс тус САА-г бүрэн хэмжээгээр хүлээлгэн өгөх ёслолын үйл ажиллагаа болж САА-н дарга Ш.Оросоод түлхүүрийг нь гардуулжээ.  
САА-г анх байгуулах үеэс Зөвлөлтийн мэргэжилтэн зөвлөх дарга А.П.Коблик, зөвлөх зоотехникч И.Ф.Ильченко, Ж.И.Ананин, А.Ф.Иванинко, зөвлөх инженер А.П.Желтов, И.В.Володя, зөвлөх малын эмч И.В.Ольга, саалийн механикжсан цогцолборын инженер Ж.И.Харламов зэрэг олон мэргэжилтэнүүд хамтран ажиллаж арга туршилгаа заан зөвлөж байжээ.
8. Жаргалант 30 жил, Н. Лхагвадулам, Ц.Бадамсэд, Эрдэнэт, 2008.

## 20. Бургалтай

1. Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сум.
2. Сэлэнгэ аймаг 1931 онд байгуулагдахад Богд хан уулын аймгийн Баруунбүрэн хан уулын хошуунаас БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчдийн 1931 оны 2 сарын 7-ны өдрийн 5-р тогтоолоор Газар тариалангийн аймгийн харьяанд байв. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1937 оны арван хоёрдугаар сарын 15-ны өдрийн 33-р хурлын тогтоолд Булган аймгийг Сэлэнгэ аймгийн зарим сумдаар байгуулахад Баруунбүрэн сум нь Булган аймгийн харьяанд очжээ. БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчдийн 1941 оны 12 сарын 11-ний өдрийн 81-р тогтоолоор 1942 оны 2-р сард

Сэлэнгэ аймгийн харьяалалд буцаан шилжүүлсэн боловч 1956 онд Сэлэнгэ аймгийг татан буулгахад Булган аймгийн харьяанд дахин очжээ. 1960 онд Сэлэнгэ аймгийг дахин байгуулсанаар Сэлэнгэ аймгийн харьяанд эргэн иржээ. Баруунбүрэн суманд 1954 онд <<Өрнөлт>> нэгдэлд байгуулагджээ. 1976 оны 10 дугаар сарын 19-ны өдөр гарсан БНМАУ-ын СнЗ-ийн 357 дугаар тогтоолоор “Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын “Өрнөлт” нэгдэл Цагаантолгойн САА-н Бургалтайн тасгийг нэгтгэн үр тариа, нарийвтар ноосны чиглэлийн Бургалтайн САА-г байгуулжээ. Үүнээс хойш сум САА болжээ.

3. 1992 он.

4. Бүрэнхан уулаас эх авсан 65 км урсаад Орхон голд цутгах Бургалтай голын хөндий дагуу байрлажээ.

5. Бургалтайн САА байгуулагдах үед Увс аймгаас сайн дураар зохион байгуулалттай, ирж суурьшсан хүмүүс байдаг. Эдгээр иргэдийг Баруунбүрэнгийн Хотонгууд гэж нэрлэдэг.

Анхны дарга нь Ц.Луузандорж, Шаамий хэмээх Лувсандаш, Т.Самбуу, Г.Санжаажав, Т.Жаваа, Жанцандорж, Р.Балдан-Осор, Ц.Гомбосүрэн, Н. Дорж, Ш.Лхамсүрэн, Я.Бадарч, Нацагдорж, Т.Доржсүрэн, Б.Нямсүндэв, П.Аюуш, Ч.Вандансүрэн, Ц.Шагдарпүрэв, Д.Бадарч/1992-1996/, М.Нордог /1996-1998/, Д.Бадарч /1998-2000/. Н.Даваадамдин /2000-2004/, Ж. Наранцэцэг /2004-2008/, Ж.Ширчмаа /2008 оноос хойш/

Анх улсын баатар Л.Дандар Увс аймгаас 21 өрх 103 хүн элсүүлэн авчирчээ. Нэгдэл САА-н даргаар Дэвшиншовгоо, Нямсүндэв, Аюуш, Шагдарпүрэв, Д.Бадарч нарын зэрэг хүмүүс ажиллаж байв. Бургалтайн САА”гаас улсын аварга малчин Д.Лувсандорж, Д.Туваандаш, Ж.Урианхай, улсын ургац хураалтын аварга М.Чулуунбаатар, Ж.Адьяасүрэн, Б.Болд, Б.Тогообор, Ж.Алгаа, Ө.Жанчив, Л.Уртнасан, Л.Мягмар, Дарамбазар, О.Бямбадаг зэрэг хөдөлмөрийн сайчууд төржээ.

6. Баруунбүрэн сум Аймгийн төвөөс 240 км зайд оршдог, 2010 оны байдлаар 2814.5 км<sup>2</sup> газар нутагтай, 3 багтай, 2850 хүн амтай, 758 өрхтэй, 127.1 мянган малтай, 21.9 мянган га тариалангийн талбайтай болсон байна.

7. Сүүний чиглэлийн хар тарлан үнээ, усалгаат тариалан эрхэлж байсан.

8. Сэлэнгэ нутаг(толь), О.Хишигсүрэн, УБ, 2003.

## 21. Орхон-Туул

1. Сэлэнгэ аймгийн Орхон-Туул сум. Сумын төв нь Баянцогт.

2. 1924 онд Богд хан уул аймгийн Баруунбүрэн хан уулын хошууны Дээд Орхон сум нэртэйгээр байгуулагджээ. 1931 оноос тус сум Байц Ивээлт сумтай нийлж Орхонтуул сум болсон. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1937 оны 12-р сарын 15-ны өдрийн 33-р тогтоолоор Сэлэнгэ аймгийн

Орхонтуул сум хэмээн нэрлэжээ.1938 онд Булган аймгийг байгуулахад Сэлэнгэ аймгаас шилжиж Булган аймгийн харьяанд очжээ. БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1941 оны 12-р сарын 11-ний 81-р тогтоолоор Булган аймгаас Сэлэнгэ аймагт шилжиж иржээ. Орхонтуул сумын “Хөгжил” нэгдэл 1956 онд байгуулагджээ. 1956 онд Сэлэнгэ аймаг татан буугдахад Төв аймагт харьяалагдаж байгаад 1959 онд Сэлэнгэ аймаг байгуулагдахад Төв аймгаас Сэлэнгэ аймагт шилжиж иржээ. 1959-1960 онд баг бригад, сум-нэгдлийн зохион байгуулалтын өөрчлөлт хийгджээ. 1972 оны 11 сарын 14-ний 357-р тогтоолоор Орхонтуул САА байгуулагдахад Орхонтуулын “Хөгжил” нэгдлийг нийлүүлж, сум нэгдлийг сум САА болгожээ.

3. 1992 онд татан буугдсан.
4. Орхон, Туул хоёр голын бэлчирт суурьшсан
5. Сумын даргаар: С.Гомбодорж, Очир, Д.Ядам, Бадарч, К.Тлеухан, Б.Балган, М.Жамсран, Б.Лхагвасүрэн, Р.Пүрэвдорж /1992-1996/, Д.Баярсайхан, Гомбо/1996-2000/, С.Жамсран /2000-2004/, П.Чулуунцэцэг /2004-2008/, С.Эрдэнэбаяр /2008 оноос хойш Сэлэнгэ үүлдэрийн үхрийг буй болгосон мал зүйч Л.Дамдиндорж, Ө.Сүхбаатар нар төрийн соёрхол хүртжээ. 1981 оны Хөдөлмөрийн баатар, хоньчин С.Гончигбал, гавьяат эдийн засагч Ө.Дашдэндэв, гавьяат агрономч Н.Цээрэн, гавьяат механикжуулагч Х. Жунсбек, гавьяат механикжуулагч Ө.Дорж, төрийн шагналт мал зүйч Л. Дамдиндорж, Ө.Сүхбаатар нарын зэрэг олон алдартан төржээ.
6. САА зөвхөн сүүлийн 20 жилд нийтдээ 267.0 мянган тонн үр тариа улсын төвлөрсөн бэлтгэл худалдааны эргэлтэд оруулсан байжээ. Аймгийн төвөөс 200 км зайд оршдог. Орхонтуул сум 2010 оны байдлаар 2940.8 км<sup>2</sup> газар нутагтай, 3 багтай, 3.6 мянган хүн амтай, 957 өрхтэй, 23,1 мянган га тариалангийн талбайтай, 157.3 мянган малтай болжээ.
7. Махны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Тус САА нь маш боловсон мал бордох талбайг байгуулан ажиллуулж байсан. Орхонтуул сум нь Сэлэнгэ аймгийн хамгийн холын сум бөгөөд газар тариалан, мал аж ахуй эрхлэн үйл ажиллагаа явуулж ирсэн юм. Газар тариалангийн үйлдвэрлэлийн бүс нутгийн онцлогийг харгалзан цоо шинээр өөрийн гэсэн технологи нэвтрүүлэн олон жилийн алдагдалтай ажилласан он жилүүдийн ургацыг нөхөн амжилтад хүрсэн газар бол Орхонтуул САА байв. “Сэлэнгэ” үхрийн шинэ үүлдэр бий болгох, Сэлэнгэ аймагт өөр газар өсгөн үржүүлж байгаагүй тэмээн сүргийг өсгөн тоо толгойг нэмэгдүүлэх чиглэлээр томоохон бодлого боловсруулан хэрэгжүүлж амжилтанд хүргэсэн юм. Газар тариалангийн уналтыг сэргээсэн учир агрономч Нянгарын Цэрэн гавьяат агрономч, “Сэлэнгэ” үүлдрийн үхэр сүрэг бий болгосон учир зоотехникч Дамдиндорж, Сүхбаатар нар төрийн шагнал хүртсэн нь

бахархал болсон билээ.

8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдагва, УБ, 1998.

## **22. Зэлтэр**

1. Сэлэнгэ аймгийн Түшиг сум. Сумын төв нь Түшиг.
2. БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1931 оны 2-р сарын 7-ны өдрийн 5 дугаар тогтоолоор Богд хан уулын аймгийн Зүүн Бүрэн хан уулын хошуунаас байгуулагджээ. 1933 онд 146 өрх, 500 хүн, 9.5 мянган малтай байжээ. 1936 онд Цагааннуур сумтай нэгдэж Түшиг-Цагааннуур сум болжээ. Түшиг сумын нутаг нь Түшээт хан аймгийн Эрдэнэ вангийн хошуунаас 1912 онд Цахарын Сумъяа бэйсийн хошуунд олгосон нутаг юм. Тус сумын харьяа 1959 онд атрын анхны Зэлтэр САА байгуулагджээ. 1977 оны 3 сарын 16-ны өдөр АИХТ-ийн 64-р зарлигаар Түшиг сум гэж нэрлэх болсон.
3. 1992 онд хувьчлагдсан.
4. Зэлтэрийн голын нэрээр нэрлэгдсэн.
5. Сумын дарга нар: Лувсаннаваан, Лхаваарэгзэн, Д.Сүхбат, Х.Маамдай, Л.Батжаргал, Д.Эрдэнэбилэг, Ш.Баясгалан, Г.Бадарч, О.Буянаа, Л. Амарсайхан ажиллажээ.
6. Түшиг сум аймгийн төвөөс 135 км-т оршдог. 2010 оны байдлаар 2492.8 км<sup>2</sup> газар нутагтай, 2 багтай, 1.5 мянган хүн амтай, 460 өрхтэй, 13,6 мянган га тариалангийн талбайтай, 35.3 мянган малтай болжээ.
7. Зэлтэрийн САА бол 1959 онд Монгол улсад анхны атар газар эзэмших хөдөлгөөн өрнөх үед улсын хэмжээнд байгуулагдсан 4 шинэ САА-н нэг юм. Уг САА харьцангуй өндөрлөг газарт орших учир байгаль цаг уурын байдлаараа бусад сумаасаа ялгардаг онцлогтой. Түшиг сум “Ууцан сүүлт” үүлдэрийн хонь, “Дон” үүлдэрийн адуу, “Халимаг” үхэр үржүүлдэг. Энэ нутагт “Хөхөө гэрлэх дөхлөө” киноны зураг авалт болжээ.
8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдагва, УБ, 1998.

## **23. Найрамдал**

1. Сэлэнгэ аймгийн Цагааннуур сум. Сумын төв нь Цагаан нуур.
2. БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1931 оны 2-р сарын 7-ны өдрийн 5 дугаар тогтоолоор Богд хан уулын аймгийн Зүүнбүрэн хан уулын хошуунаас байгуулжээ. 1933 онд 636 өрх, 2200 хүн, 44.9 мянган малтай байв. 1936 онд татан буулгаж Түшиг суманд нийлүүлээд Түшиг-Цагааннуур сум болжээ. 1956 онд Сэлэнгэ аймгийг татан буулгахад Булган аймгийн харьяанд шилжүүлжээ. 1958 онд Сүхбаатар сум байгуулагдахад

тус сумын харьяанд оруулжээ. 1976 оны 11-р сарын 1-нээс Зэлтэрийн САА-н Цагааннуурын тасгийг түшиглүүлэн үр тариа ургуулах, нарийн ноост хонь үржүүлэх “Найрамдал” САА-г байгуулжээ. БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1977 оны 3-р сарын 16-ны өдрийн 64 дүгээр Зарлигаар “Найрамдал” САА-г харьяалсан Цагааннуур сум байгуулжээ.

3. 1992 онд хувьчлагдсан.
- 4.
5. Сумын дарга нар: Ч.Аюур, Д.Ядам, К.Тлеухан, Ц.Лхагвасүрэн, К.Тлеухан /1992-1996/, Ч.Жаргалсайхан /1996 оноос хойш ажиллаж байна.  
Ж.Самбуугийн нэрэмжит МАА-н эрдэм шинжилгээний хүрээлэнгийн ахлах ажилтан, ХАА-н дэд эрдэмтэн Б.Аюуш, Сэлэнгэ аймгийн “Найрамдал” САА-н хонины ноосны гарцыг нэмэгдүүлэх зорилгоор 20 шахам жил явуулсан эрдэм шинжилгээний ажлын үр дүнд нарийн ноосны “Хангай” үүлдрийн хонины хэсгийг буй болгожээ.
6. Цагааннуур сум 1985 онд 52426 тн, 1988 онд 71500 тн үр тариа хураан авч усалгаагүй 1га талбайгаас 27,8 цн ургац авч улсын дээд амжилт тогтоосон нь одоо ч эвдэгдээгүй байна. “Найрамдал” САА-г харьяалсан Цагааннуур сум 1994 оны байдлаар 600 өрх, 3000 хүн, 46.0 мянган малтай байжээ. Тус сум “Хангай” үүлдрийн нарийн ноост хонь бий болгон нутагшуулсан газар юм. Нас гүйцсэн “Хангай” үүлдэрийн эр хонь 90кг жин татаж, 3,5кг ноос өгч байв.  
2010 оны байдлаар Цагааннуур сум 1.1 мянган өрхтэй, 4 мянган хүн амтай, 3814.7 км<sup>2</sup> газар нутагтай, 3 багтай, 121.3 мянган малтай, 52,1 мянган га тариалангийн талбайтай болжээ.
7. Зэлтэрийн САА-н Цагааннуурын тасгийг ЗХУ-ын тусламжаар түшиглүүлэн үр тариа ургуулах, нарийвтар ноосны хонь үржүүлэх чиглэлээр байгуулжээ.
8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдагва, УБ, 1998.

## 24. Зүүнбүрэн (Коминтерн)

1. Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сум. Сумын төв нь Жаргалант.
2. 1930 онд Коминтерны нэрэмжит сангийн аж ахуй байгуулагдсан. 1933 онд Монгол Ардын хувьсгалт намаас САА-г ашиггүй ажилласан хэмээн САА-г татан буулгах шийдвэрийг намаас гаргав. Үүний улмаас “Коминтерн”-ы САА татан буугдсан. БНМАУ-ын СнЗ-ийн тэргүүлэгчдийн 1943 оны 4-р сарын 2-ны өдрийн хамтарсан хуралдаанаар станцыг татан буулгаж САА болгох тухай 30\36-р тогтоолоор баталжээ. БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1956 оны 7-рсарын 27-ны өдрийн 102 дугаар Зарлигаар Сэлэнгэ аймгийг татан буулгахад Төв аймагт шилжжээ. БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1959 оны 12-р сарын 31-ний өдрийн 222 дугаар

Зарлигаар Сэлэнгэ аймгийн дахин байгуулахад Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сум болжээ.

- 3.
4. Боогма хэмээн газар төвлөрсөн.
5. Сумын дарга нар: Санжаажав, П.Цогтзанаа, Х.Дашдондов, Б.Төмөрчөдөр, Д.Ламжав, Д.Чулуун, Ц.Шагдарпүрэв, Л.Нарангэрэл, М.Доржсүрэн, Б.Төмөр-Очир /1992-1996/, Ц.Лхагважав, Б.Доржпүрэв /1996-2000/, Ц.Батжаргал /2000-2004/, М.Доржсүрэн /2004-2008/, Б.Батчулуун /2008 оноос хойш/
6. 1961 онд тус САА нь газар тариалангийн 5 бригад, эрдэнэ шиш жимс жимсгэний 2 салааны 136 байнгын ажилтантай байсан бөгөөд, 2500 га талбайг 600 тн бууц, 15 тн сангасаар бордож Орхон-Мельнопусь-63, Лютесченьс-62 сортын улаан буудай, Раный-1 сортын эртний байцаа, бессносский сортын сонгино, Берлинхенгейн сортын төмсний үрээр тариалж байжээ. 1933 онд 702 өрх, 2600 хүн, 60.2 мянган малтай байжээ. 120 мянган га нутаг дэвсгэртэй, 2468 хүн амтай, 63.9 мянган малтай, Газар тариалан, МАА, үйлдвэрлэл эрхэлдэг байв. Аймгийн төвөөс 50 км зайтай, Чацаргана тариалалтыг түлхүү хөгжүүлж байгаа. Зүүнбүрэн сум 2010 оны байдлаар 1204.9 км<sup>2</sup> газар нутагтай, 3 багтай, 2.7 мянган хүн амтай, 900 өрхтэй, 16,2 мянган га тариалангийн талбайтай, 57.7 мянган малтай болжээ.
7. Анх байгуулагдах үедээ Сэлэнгэ нэртэй байсан боловч, 1945 оноос Зүүнбүрэн гэж нэрлэх болжээ. 1967 онд Шаамар сум, Найрамдал нэгдэл татан буугдаж мал, хөрөнгө, газар нутаг нь Зүүнбүрэнгийн САА-д шилжин ирсэн байна.
8. Уваши Мэргэдийн унаган нутгийнхны хураангуй шастир, Ө.Бавуу, УБ, 2004.  
Сэлэнгийн түүхийн товчоо, Ө.Бавуу, Сүхбаатар, 2001.

## **25. Алтанбулаг**

1. Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сум. Сумын төв нь Алтанбулаг.
2. Анх Манжийн Гадаад Монголын төрийг засах яамны харьяа “Жургааны занги” нэртэйгээр 1729 оны эхээр хилийн худалдааг зохицуулах, худалдаачдыг баримтлан захирах газар байгуулагдсанаар “Хиагт” хотын эх үүсвэр тавигджээ. 1921-1931 онд Засгийн газрын Алтанбулагийн сайдын яам ажиллаж байжээ. БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчдийн 1931 оны 2-р сарын 7-ний өдрийн 5-р тогтоолоор аймгийн төв болгожээ. 1921 оны 3 сарын 18-нд Монгол Ардын Журамт Цэрэг Алтанбулаг хотыг чөлөөлсөнөөр Ардын хувьсгалын ялалтыг эхлүүлсэн нутаг. 1931 онд Сэлэнгэ аймгийн төв Алтанбулаг сум нэртэй байсан байна. 1938 онд

Булган аймаг байгуулагдахад Сэлэнгэ аймгийн үндсэн сумууд дахин зохион байгуулалтад орж Алтанбулаг сум татан буугдаж Шаамар суманд нэгджээ. 1956 онд САА байгуулагдаж сум-САА болжээ. 1956-1959 онд Төв аймагт харьяалагдаж, Сүхбаатар хотод хамаарагдаж дагуул суурин байдалтай байжээ. 1960 онд “САА” болж байгуулагдсан.

3. 1992 онд хувьчлагдсан.
4. Алтанбулаг.
5. Алтанбулагын сум-САА-н дарга нар:  
Өлзийтогтох, Намжил, Гомбодорж, Норовсамбуу, Н.Нямжаргал, 1960 онд Жигмэддорж, Я.Намжаа, Л.Чойжамц, Д.Ламзав, О.Жигжид, С.Цэвээндорж, Д.Энхбат, Ж.Баярмагнай, Ж.Бямбаа, САА-н ногоочин, хөдөлмөрийн баатар Б.Туяа нар ажиллаж байв.
6. Тухайн сум САА-н төвд хувьсгалын музей, соёлын төв, арван жилийн дунд сургууль, 60 айлын орон сууц 6, бүх төрлийн ХАА-н машин, 80 трактор засварын газар, 400 үнээний саалийн механикжсан ферм, үр тарианы механикжсан үтрэм, 400 оюутны дотуур байр, ХАА-н техникум зэрэг үйлчилгээний барилга байгууламжыг техник эдийн засгийн тусламжаар байгуулжээ. 2010 онд Алтанбулаг сум 2100.3 км<sup>2</sup> газар нутагтай, 3 багтай, 5.1 мянган хүн амтай, 1.4 мянган өрхтэй, 34.3 мянган малтай, 12,6 мянган га тариалангийн талбайтай болжээ.
7. Нутгийн үндсэн иргэд нь 1955 онд МХЗЭ-ийн илгээлтээр ирсэн хүмүүс байдаг. Алтанбулаг сум гэж байхдаа 1933 онд 269 өрх, 700 хүн, 1.7 мянган малтай, 210.0 мянган га нутаг дэвсгэртэй, газар тариалан, МАА эрхэлдэг байжээ. Эдийн засаг худалдааны чөлөөт бүс Монгол-Оросын шалган нэвтрүүлэх боомттой, хувьсгалын музей, Улсын анхны бага сургууль, банк болон шүүхийн байшин, Ардын Намын Төв хороо, АТЗГ-ын анх байрлаж байсан байшин тус суманд байдаг. Хувьсгалын өлгий Алтанбулаг сумын хөрс шорооноос 1981 онд сансрын нисгэгч Ж.Гүүррагчаа сансарт дээж авч ниссэн түүхтэй.
8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдагва, УБ, 1998.

## 26. Шаамар

1. Сэлэнгэ аймгийн Шаамар сум. Сумын төв нь Дэлгэрхан.
2. БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1931 оны 2-р сарын 7-ны өдрийн 5 дугаар тогтоолоор Богд хан уулын аймгийн Зүүнбүрэн хан уулын хошуунаас байгуулжээ. 1933 онд 656 өрх, 2400 хүн, 30.3 мянган малтай байв. 1956 онд Сэлэнгэ аймаг татан буугдаж, Төв аймагтай нийлэхэд Төв аймгийн Сүхбаатар суманд нэгтгэжээ. 1960 онд Сэлэнгэ аймгийг дахин байгуулахад Шаамар сум болжээ. Шаамар сумын



“Найрамдал” нэгдэл 1956 онд байгуулагджээ. 1954 онд Орхон Шаамарын жимсний туршилгын станц нэргэйгээр анх байгуулагджээ. 1968 онд Шаамарын тэжээлийн аж ахуйг байгуулжээ. БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1972 оны 4-р сарын 12-ны өдрийн 75 дугаар Зарлигаар Шаамар хороог Шаамар сум хэмээн нэрлэжээ.

3. 1991-1993 онд олон жижиг аж ахуй болон задарч байснаа 1995 онд дахин нэгдэж Соёл захиралтай “Ундрагч” компани болж үр тариа, хадлан бэлтгэл эрхэлж байна.
4. Орхон Шаамарын жимсний станцыг ШУА-ын тухайн үеийн Хөдөө Аж Ахуйн Ухааны Хүрээлэн байгуулж байсан ба Академич Тойвгоо, Академич Бадгаа, доктор Шагдар, доктор Б.Лааган, Самбуу, Бааст, Цэрэндондов, Жүгдэр зэрэг Хөдөө Аж Ахуйн Хүрээлэнгийн үе үеийн эрдэмтэн болон бусад хүмүүс жимс-жимсгэнэ, зөгийн бал зэргийг судлан шинжлэж ажиллаж байжээ.
5. Сумын даргаар: Бат-Очир /залан/, Цэвээндорж, Доржхорлоо, Н.Норов, С.Доржпалам, Ц.Сүрэн-ухнаа, Б.Сайнжаргал, Б.Мандаа, Ө.Бавуу, Б. Сайнжаргал /1992-1996/, Н.Цэрэнванчиг /1996-2000/, Ж.Батсайхан /2000-2004/, Ч.Санжаажав /2004-2008/, Д.Бямбасүрэн /2008 оноос хойш/  
Тэжээлийн аж ахуйн анхны дарга нь Ц.Сүрэн-Ухнаа юм. 1970-аад онд Шаамарын ТАА-д өвсний гурил хийдэг цех байгуулагдсан. Нийт ажиллагсдын 86% нь МХЗЭ-ийн илгээлтийн эзэд байсан бөгөөд БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн 1976 оны зарлигаар Тэжээлийн аж ахуйг МХЗЭ-ийн нэрэмжит болгожээ.
6. 1955 онд 10 шахам га газрыг боловсруулж жимс-жимсгэний 20 гаруй сортын ургамал тарьж эхэлсэн байна. 1960 он болоход 30 гаруй га газар 60 гаруй сортын жимс-жимсгэнэ тарьж, алимны мод 4370, жимсний бут 6000 байгаагаас 12 тонн ургац хурааж байжээ. 1965 онд 169.7 мянган га нутаг, 520 малчин гишүүн, нийгмийн өмчийн 19 мянган мал, 1.8 сая төгрөгийн мөнгөн орлого, 2.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй болсон байв.  
Шаамар дахь зөгийн аж ахуй 1980-аад он гэхэд 20 тонн бал хураадаг бие даасан том аж ахуй болтлоо хөгжсөн байна. Шаамар сум 2010 оны байдлаар 671.9 км<sup>2</sup> газар нутагтай, 3 багтай, 3968 хүн амтай, 1.1 мянган өрхтэй, 3,6 мянган га тариалангийн талбайтай, 21.2 мянган малтай болжээ.
7. 1959 онд ЗХУ-аас зөгийн 20 бүл авч нутагшуулан үржүүлэх туршилтыг Шаамарт эхэлсэн нь монголд зөгий үржүүлж эхэлсэн анхны тохиолдол байлаа. Шаамар сум нь монгол оронд нутагшсан анхны алим ургуулж, нутгийнхаа тэнгэрт 90 сая зөгий анх нисгэж түүхнээ гайхамшигийг бүтээж үлдээсэн нутаг юм. 1956 оноос жимс, жимсгэний эрдэм шинжилгээний станц ажиллаж 40 гаруй нэр төрлийн жимс, жимсгэний сорт тарьж

ургуулан, Монголд анхны алим ургуулсан түүхтэй юм. Монгол алим бүтээсэн эрдэмтэн Эрдэнэбаатарын Шагдар төрийн шагнал хүртэж байжээ. Шаамар сум монгол орны байгалийн хадлангийн улсын фондын дийлэнх хувийг төвлөрүүлэн бэлтгэж байсан том тэжээлийн аж ахуй байв. Тус суманд “Ээж мод, Тужийн нарс, Хайлаастын дуган зэрэг түүх дурсгалын газрууд, Ази-Европыг холбосон авто болон төмөр зам дайран өнгөрдөг. Шаамарын хөдөө аж ахуйн техник мэргэжлийн сургууль нь сургууль комбинат нэртэйгээр үйл ажиллагаагаа эхэлж атрын анхдугаар болон хоёрдугаар аяныг амжилттай хэрэгжүүлэхэд мэргэжилтэй ажилчдыг бэлтгэн гаргаж байсан түүхээрээ алдаршсан юм.

8. Шаамар дахь жимс-жимсгэний улсын туршлага станцын бүтээл I, Шинжлэх Ухааны Академи, УБ, 1963.

Шаамар дахь жимс-жимсгэний улсын туршлага станцын бүтээл №4., Шинжлэх Ухааны Академи, УБ, 1977.

Сэлэнгэ нутаг(толь), О.Хишигсүрэн, УБ, 2003.

## 27. Хүдэр

1. Сэлэнгэ аймгийн Хүдэр сум. Сумын төв нь Булагтай.
2. Монгол улсын Засгийн газрын 1924 оны 10-р сарын 18-ний өдрийн 42-р тогтоолоор Богдхан уулын аймгийн Галтайн буриад хошуу хэмээх засаг захиргааны шинэ нэгж байгуулагдаж Хүдэр, Шоргоолж голуудын бэлчир орчим төвлөрүүлсэн нь одоогийн Хүдэр сумын тулгын чулуу тавигдсан түүхийн эхлэл юм. 1972 оны 4 сарын 14 нд байгуулсан.. БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1973 оны 10-р сарын 31-ний өдрийн 279 дугаар Зарлигаар Хүдэр сумын хилийн цэсийг баталжээ.
3. 1992 онд хувьчилагдсан.
4. Норовбанзадад төвлөрөх болсон.
5. Сумын даргаар: Н.Цэрэндаш, Н.Энэбиш, Н.Дуламсүрэн, Ч.Ядамжав, Г.Хашбаатар, Г.Дэмбэрэл, Г.Хашбаатар /1992-2003/, Т.Баасандорж /2003-2004/, Б.Мөнхтөр /2004-2010/, Ч.Баатаржав /2010 оноос хойш/ нар ажиллажээ.  
Анхны дарга нь Намсрайн Цэрэндаш, мөн анхны ерөнхий инженер Х.Дансандорж хожим ХХААЯ-ны орлогч даргаар ажиллаж байсан.
6. Улсын төвлөрсөн хөрөнгө оруулалтаар МТЗ-80, 83 маркийн 108 трактор, хадлангийн бүрэн төхөөрөмж, 1500 толгой үхэр, 4000 толгой Монгол хонь, 200 толгой адуу, 3-р тасгийн үр тарианы техник тоног төхөөрөмж нийт 16.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй анх байгуулагджээ. Хүдэр сум 2010 оны байдлаар 2838.7 км<sup>2</sup> газар нутагтай, 2 багтай, 2.1 мянган хүн амтай, 560 өрхтэй, 9,4 мянган га тариалангийн талбайтай, 25 мянган малтай болжээ.

7. 1971 оны 6 сарын 25-ны 202 тогтоолоор Ерөөгийн САА-н 3-р тасгийг өргөтгөн жилд 20 мянган тонн байгалын хадлан бэлтгэж улсын тэжээлийн нөөцөд нийлүүлэх үүрэг бүхий “Хүдэр” ТАА-г байгуулжээ.  
Хүдэр сумыг тусад нь байгуулах үндсэн шаардлага нь жилд 20,0-30,0 мянган тн байгалийн хадлан бэлтгэн улсын төвлөрсөн хэрэгцээнд нийлүүлэн үр тариа, МАА, үхрийн аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулахад оршиж байв. Хүдэр сум улсын фондын хадлан бэлтгэх төлөвлөгөөг амжилттай биелүүлж байсан нутаг юм. Одоо тус суманд улаан буудай, төмс, хүнсний ногоо тариалах, аялал жуулчлал хөгжүүлэх, байгалийн баялаг ашиглах чиглэлээр ард иргэд нь үйл ажиллагаа явуулж Хүдэр дунгуй нутгийн “Гүзээлзгэний ханд”, Тагар сонгино, “Чаг мөөгний ханд”, зэрэг бүтээгдэхүүнүүд нь бренд болжээ. Хүдэр сум нь Монгол орны хилийн сум учир хөрш зэргэлдээ ОХУ-ын хамтралуудтай холбоо харилцаа тогтоон, эв эеийг хичээн 1972 оноос хойш “Эв модны наадам”-ыг сэргээн тасралтгүй зохион байгуулж ирсэн юм.
8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдагва, УБ, 1998.

## 28. Ерөө

1. Сэлэнгэ аймгийн Ерөө сум. Сумын төв нь Тавин.
2. БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1931 оны 2-р сарын 7-ны өдрийн 5 дугаар тогтоолоор байгуулагджээ. Сэлэнгэ аймаг татан буугдахад Төв аймагт харьяалагдаж, Сүхбаатар хотод хамаарагдаж байв. 1959 онд САА-г байгуулсан.
3. 1992 онд татан буугдсан. Монгол Улсын Их Хурлын 1994 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 36 дугаар тогтоолоор Ерөө хороог татан буулгаж Сэлэнгэ аймгийн Ерөө суманд нийлүүлжээ.
4. Ерөө голын сав, Буурагчин уулын бэл
5. Сум-САА-н даргаар ажиллаж байсан хүмүүс:
  - 1924-1930 он Б.Ренчин
  - 1930 он А.Доржпалам
  - 1930-1947 он Базарын Чүлтэм
  - 1948-1952 он Сономын Рэнцэн
  - 1952-1954 он Петрушка
  - 1954-1956 он Балдан-Осор
  - 1956-1961 он Д.Загдгочоо
  - 1961-1962 он Ц.Жамбал
  - 1962 он Т.Юмжав
  - 1963-1984 он Н.Нямжаргал
  - 1984-1990 он Б.Пүрэвжав

1992-1995 он Ц.Энхсайхан

1995-1997 он Ж.Пүрэвдорж

1997-1999 он Ц.Гүнчинсүрэн

1999-оноос С.Шараа

1958 онд тракторч, комбайнч Н.Бямбацогт 1958 онд “БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар” цолыг хүртсэн.

Г.Чадраабалын удирдлагаар мах сүү нарийвтар ноосны чиглэлийн “Ерөө” үүлдийн хонийг гаргаж авсан.

Тус сумаас Хөдөлмөрийн баатар Н.Бямбацогт, Г.Лувсанчимэд, Д.Баттөр, М.Алтангэрэл, Б.Дашзэвэг, Ж.Чулуунбаатар, Д.Даш, ардын жүжигчин Л.Жамьянжав, гавьяат эдийн засагч Н.Нямжаргал, гавьяат механикжуулагч С.Ганболд, ойн гавьяат ажилтан Ч.Чангас, гавьяат усжуулагч Н.Должинжав, ХАА-н ухааны доктор, төрийн шагналт Р.Жавзмаа, доктор Дулмаа, Га.Цэрэндорж, Ж.Шагж, Д.Батжаргал, Ц.Тойвгоо, газар зүйн ухааны доктор Б.Гунгаадаш, дуучин В.Пунцаг нарын алдартнууд төрөн гарчээ.

6. 1933 онд 596 өрх, 2100 хүн, 23.5 мянган малтай байжээ. 1955-1956 онд тус САА-ын малчин Колоо өөрийн хариуцсан эм хониноос сэрүүн нөхцөлд төлийг бойжуулан авсан байна. 486 эм хониноос 491 хурга төллүүлж, 766 кг ноос тушаахаас 1029 кг тушааж, сүргээ өсгөх төлөвлөгөөг 104 хувь биелүүлсэн байна.

1994 онд Ерөө голын сав дагуу 820.0 мянган га нутагтай, 20.5 мянган малтай, 24 мянган га-д үр тариа тарьдаг, 30 га-д хүнсний ногоо ургуулдаг 160 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, 1931, 1982, 1983 онд ургац хураалтаар улсад тэргүүн байр эзэлж байсан САА байв. Ерөө сум 2010 оны байдлаар 8203.5 км<sup>2</sup> газар нутагтай, 3 багтай, 6.4 мянган хүн амтай, 1.8 мянган өрхтэй, 23,0 мянган га тариалангийн талбайтай, 62.6 мянган малтай болжээ.

7. Газар тариалан, нарийвтар ноост хонь үржүүлгийн чиглэлээр, ХАА-н үйл ажиллагаа явуулж иржээ.

Ерөө САА хураан авах ургацын төлөвлөгөөг 208.9 хувиар, улсад тушаах будааг 208 хувиар давуулан биелүүлж, урьд өмнө байгаагүй амжилт гаргасан тул БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1959 оны 10-р сарын 31-ны өдрийн 176 дугаар Зарлигаар “Хөдөлмөрийн гавьяаны улаан туг”-ийн одонгоор шагнагджээ. 1950-иад оны дунд үеэс газар тариалангийн үйлдвэрлэл өргөнөөр эрхэлж монгол оронд үр тарианы үйлдвэрлэлийн томоохон салбар үүсэж болохын үлгэр дуурайллыг үзүүлсэн нутаг бол Ерөө юм. Тиймч учраас атар газар эзэмших анхны хөдөлгөөн эхлэхээс 1 жилийн өмнө Н.Бямбацогт газар тариалангийн салбараас анхны баатар цол хүртэж түүхнээ алтан үсгээр бичигдэх гавьяат үйлсийн эзэн болсон билээ. “Ерөө” сум нарийвтар ноост “Ерөө” үүлдэрийн

хонин сүрэг бий болгон баталгаажуулсан нутаг. Ерөө нутаг 1926 онд Ерөө голын алтны уурхай, 1946 онд Бороогийн алтны уурхай, 1974 онд Толгойтын алтны уурхайг нээн ажиллуулж байсан алт эрдэнэсээр баян нутаг юм. Ерөөгийн модны үйлдвэрийг түшиглүүлэн БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1961 оны 1-р сарын 9-ний өдрийн 7 дугаар Зарлигаар Ерөө хороог байгуулжээ. Бугантад мод бэлтгэлийн аж ахуйн дэргэд БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1971 оны 3-р сарын 2-ны өдрийн 55 дугаар Зарлигаар байгуулсан хороо захиргааг АИХ-ын Тэргүүлэгчдийн 1972 оны 4-р сарын 12-ны өдрийн 75 дугаар зарлигаар татан буулгаж, Ерөө хороотой нэгтгэн төвийг нь Бугантад төвлөрүүлжээ.

8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдагва, УБ, 1998.

## **29. Баянхараат**

1. Сэлэнгэ аймгийн Жавхлант сум. Сумын төв нь Баянхараат.
2. 1977 оны 1 дүгээр сарын 1 нд байгуулагдсан. Ерөөгийн САА-н хоёрдугаар тасгийг түшиглүүлэн үр тарианы чиглэлийн Баянхараат САА-г байгуулсан тул БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1977 оны 3-р сарын 16-ны өдрийн 64 дүгээр Зарлигаар Сэлэнгэ аймгийн Баянхараатын САА-г харъяалсан Жавхлант сум гэж нэрлэхээр тогтжээ.
3. 1992 онд татан буугдсан.
4. Баянхараат уулын нэрээр нэрлэгдсэн.
5. Сумын даргаар: Д.Пүрэвсүрэн, Ц.Маандай, А.Намжилдорж, Ш.Чойжоо, С.Нямсүрэн, Д.Хэнмэдхэвхүү /1992-1996/, П.Буяндалай /1996-2000/, С.Нямсүрэн /2000-2004/, Х.Цэрмаа /2008 оноос хойш/  
Тус САА-н даргаар Д.Пүрэвсүрэн ажиллаж байхдаа үйл ажиллагаа нь тогтвортой дээшилж байсан учир БНМАУ-ын АИХ-ын депутатаар сонгогдон ажиллаж байжээ.
6. 118.9 мянган га газар нутагтай газар тариалан, МАА, нутгийн өндөр ашигт шимт мал өсгөдөг. Жавхлант сум одоо МАА, үр тариа, төмс, хүнсний ногоо тариалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Жавхлант сум 2010 оны байдлаар 1189.7 км<sup>2</sup> газар нутагтай, 2 багтай, 1.9 мянган хүн амтай, 634 өрхтэй, 17,1 мянган га тариалангийн талбайтай, 81.7 мянган малтай болжээ. Сумын төв нь Жаргалант.
7. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдагва, УБ, 1998.

## **30. Номгон**

1. Сэлэнгэ аймгийн Сайхан сум.
2. БНМАУ-ын СнЗ-ийн 1976 оны 11-р сарын 19-ний өдрийн 357 дугаар

тогтоолоор Орхон САА-н Номгоны тасгийг түшиглүүлэн үр тариа, нарийвтар ноосны чиглэлийн хонь үржүүлэх “Номгон” САА-г байгуулжээ. БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1977 оны 3-р сарын 16-ны өдрийн 64 дүгээр Зарлигаар Номгон САА-г харьяалсан Сайхан сум байгуулж, төвийг “Номгон” гэж нэрлэхээр тогтжээ.

3. 1992 онд хувьчлагдсан.
4. Төв нь Номгон.
5. Сумын дарга нар: Н.Пэрэнлэй, Ш.Балдандорж, Цэдэн-Иш, Сүрэнжаргал, С.Цэдэн-Иш, Н.Баярмөнх /1992-1996/, Ц.Сампилноров /1996-2000/, О. Буянаа /2000-2004/, Р.Шийлэгжамбал, Б, Ширчинжав /2004-2008/, С. Энхтайван /2008 оноос одоог хүртэл/. Анхны дарга нь Нацагийн Пэрэнлэй бөгөөд 1990 он хүртэл тасралтгүй удирдсан юм.
6. Зөвхөн Хөтөл хотод 7200 хүн оршин суудаг. Сайхан сум 2010 оны байдлаар 1311.9 км<sup>2</sup> газар нутагтай, 3 багтай, 8.8 мянган хүн амтай, 2.3 мянган өрхтэй, 25,6 мянган га тариалангийн талбайтай, 76.7 мянган малтай болжээ.
7. Үр тариа нарийвтар ноосны чиглэлийн хонь үржүүлдэг. 1977 онд Номгон САА-г харьяалсан Сайхан сумыг байгуулжээ. Тус сумаас БНМАУ-ын хөдөлмөрийн баатар цолыг тариаланч Самбуу хүртсэн байна.
8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдагва, УБ, 1998.

### **31. Цагаан толгой**

1. Сэлэнгэ аймгийн Сант сум.
2. 1959 онд байгуулагдсан.
3. 1992 онд хувьчлагдсан.
4. Цагаантолгой нэрт газарт 1944 онд нүүж ирснээр нэрлэгджээ.
5. Сумын даргаар: Цэвэгдорж, Нида, Доржрэнцэн, Ц.Гармаа, Л.Нарангэрэл, Г.Жалбаа, Ж.Норовсамбуу, Г.Уртнасан, Л.Батдорж, Д.Вандан, Д. Өлзийбадрах нар ажиллажээ. Бира анхны дарга нь бөгөөд түүнээс хойш сум-САА-н даргыг давхар хаших болсон 32 жилийн дотор 15 хүн солигджээ. Хамгийн удаан даргаар ажилласан нь 1968-1979 онуудад Ц. Гармаа байв. Хамгийн богино хугацаанд 1963-1964 онд Нядаа юм. Тус САА-гаас төрөн гарсан олон алдартнууд байдаг. Тухайлбал БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар Ж.Баасан, М.Эрхэмбаяр улсын хошой аварга малчин Дүгэржав нарын алдартнууд төржээ.
6. 1954 онд 1300 га үр тарианы усалгаатай талбайн байгууламжийн нэгдүгээр ээлжийг ашиглалтанд оруулсан.  
Сант сум казахын цагаан толгойт үхэр, “Орхон” хонь, Ховдын ноолуурын улаан ямаа голлон үржүүлж байдаг. Жилд дунджаар 3000 тн төмс, 900 тн

хүнсний ногоо хураан авдаг. Сант сум монголын газар тариалангийн түүхийн эрдэм шинжилгээний туршилтын нэгэн төв болж байсан газар юм.

Сант сум 2010 оны байдлаар 1387.0 км<sup>2</sup> газар нутагтай, 2 багтай, 2.2 мянган хүн амтай, 680 өрхтэй, 7,0 мянган га тариалангийн талбайтай, 62.5 мянган малтай болжээ.

7. 1924 оны 8-р сарын 30-нд Богдхан уулын аймгийн /Ахай гүний/ Баруунбүрэн хан уулын хошууг анх байгуулах Баруунбүрэн хан уулын хошууны төлөөлөгчдийн 1926 оны 8-р сарын 12, 13, 14, 15-ны өдөр хуралдсан Их хурлын 3-р тогтоолд хошууны 4 сумын захиргааг хаана байгуулахыг хэлэлцээд "...Далхбаян сумын төвийг Баян уулын өмнө этгээдэд байрлуулан суурьшуулахаар тогтов" гэжээ. Энэ нь Сант сумын анхны үүсэл юм. Сэлэнгэ аймгийн Хушаат сумын нутагт Орхон Хараагийн бэлчир, Энхталын хөндийн эхэнд Доной Жин уулын өвөрт 1928 онд "Энхталын сангийн газар" нэртэй байгуулагдсан газар тариалан, МАА-н үйлдвэрлэл эрхлэх улсын САА 1944 онд Баруунбүрэн сумын нутаг "Цагаан толгой"-д нүүж очсноор Цагаан толгой САА байгуулагджээ. 1954 оноос Казакын цагаан толгойт үхэр үржүүлж эхэлжээ. 1954 онд Ивэн голын далан, Цагаантолгойн усалгааны суваг хэмээх анхны усалтын систем ашиглалтад оржээ.

Сант суманд хөдөө аж ахуйн болон бусад мэргэжил эзэмшүүлэх ТМС байгуулагдан эдүгээ Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв болон өргөжин үйл ажиллагаа явуулж байна. Сант сумын нутаг Моностойн аманд "Уяхан замбуутивийн наран" киноны зураг авалт болжээ.

8. Сэлэнгийн түүхийн товчоон, Ө.Бавуу, Сүхбаатар, 2001.

## **32. Энх тал**

1. Сэлэнгэ аймгийн Хушаат сум. Сумын төв нь Энхтал.
2. 1930 онд улсын VI их хурлын тогтоолоор мал ба тариалан эрхэлсэн САА байгуулсан. 1931-1932 онд үед зүүнтний алдаа завхарлын үед САА-д олноороо алдагдалтай ажилласан учир 1933 онд үйл ажиллагаа нь хумигдаж зөвхөн 500 газар туршилгаар тариалж байсан. Энэ нь сүүлдээ бүр багассан байна. 1956-1959 онд Төв аймагт харьяалагдаж байв. 1960 онд Сэлэнгэ аймагт шилжиж ирээд татан буугдаж 1, 2, 3, 5, 6-р багийг Дархан суманд, 4-р багийг Баруунбүрэн суманд нийлүүлжээ. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1986 оны 329-р тогтоолоор Хушаат сум дахин байгуулагджээ. БНМАУ-ын СнЗ-ын 1986 оны 9 сарын 4-ний өдрийн 329-р тогтоолоор Цагаантолгойн САА-н Энхталын тасгийг өргөтгөж, Энхтал САА-г шинээр байгуулсан.
3. 1992 онд хувьчилагдсан.

4. Сумын захиргаа нь тэр үедээ Бажгир-улааны өвөрт төвлөрч байсан.
5. Шинээр байгуулагдсан САА-н даргаар нутгийн иргэдийн хүсэлтийн дагуу агрономич УИХ-ын депутат байсан Халтарын Намсрайжавыг МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга нарын зөвлөгөөний шийдвэрээр томилжээ. Сумын Засаг даргаар: Х.Намсрайжав /1992-1996/, Г.Гомбожав, Н.Лхагважаргал, Н.Гантөмөр /1996-2000/, Б.Сүхээ /2000-2004/, О.Бат-Очир /2004-2008/, О.Бат-Очир, Б.Агартулга /2008 оноос хойш/
6. Анх 150 өрх, 770 хүн амтай, 6012 толгой мал, 21.5 мянган га тариалангын талбай, 18.0 сая төгрөгийн хүнтэй жижгэвтэр сум-САА байлаа.Хушаат сум 2010 оны байдлаар 2010.2 км<sup>2</sup> газар нутагтай, 2 багтай, 1.7 мянган хүн амтай, 479 өрхтэй, 21,8 мянган га тариалангийн талбайтай, 76.9 мянган малтай болон өргөжжээ.
7. 1931 онд Монгол эм хонь 16000-ийг хээлтүүлсэн боловч, хургалсан 4000, сувайрсан 1200, бойжуулсан 4000 хурганаас, 3721 нь хамуу өвчнөөр үхэж 270 нь үлджээ. 1931 онд тус САА-д зохиомол хээлтүүлгийн улсын анхны тасаг байгуулагдан ажилласан.“Казакийн цагаан толгойт” үхэр үржүүлдэг. Хушаат суманд Австралийн “Аранбуль” үүлдэрийн хонин сүрэг нутагшуулсан газар юм.
8. Сэлэнгийн түүхийн товчоон, Ө.Бавуу, Сүхбаатар, 2001.

### 33. Орхон

1. Сэлэнгэ аймгийн Орхон сум.
2. 1943 оноос Жаргалантын САА-н Орхон дахь хонины туршлагын фермд шилжүүлэн үржлийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулалтай явуулж эхэлжээ. Орхон сум 1959 онд байгуулагджээ.
3. 1991 оноос Орхон үүлдийн хонийг хувьчилж олон жижиг хэсэг болгон задарчээ. Одоо Орхон, Номгон, Цагаантолгой зэрэг сумдад үржүүлж байна.
4. Сэлэнгэ аймгийн нутаг Орхон голын дагуу оршино.
5. Сумын даргаар: Д. Ядам, Г.Цэнджав, А.Амжаа, Жадамбаа, С.Содхүү, Ш.Дөрвөнжин, А.Амжаа /1992-1996/, Ш.Дөрвөнжин /1996-2000/, Н. Энэбиш /2000-2004/, Ё.Батцэнгэл /2004-2008/, Г.Булганчимэг /2008 оноос хойш/ нар ажиллажээ.  
1943 оноос МУИС-ын Зоотехникийн факультетийн багш Т.Аюурзана, ЗХУ-ын эрдэмтэн Г.Р.Литовченкогийн хамтаар Орхон САА-д хонины үржлийн ажлыг анх удаа зохион байгуулж эрдэм шинжилгээний ажлыг гарган хийсэн нь манай улсын хэмжээнд мал үржлийн ажлыг шинэ түвшинд гаргах эхлэл байжээ. 1947 онд МУИС-ын анхны төгсөгчдийн нэг С.Аюуш, 1951 онд төгссөн Б. Аюуш нар энэ ажилд гардан оролцох болжээ. 1957 онд “Орхоны САА-д нарийвтар ноост хонины үржлийн бааз



бий болгох арга зам” сэдвээр дэд эрдэмтний зэрэг хамгаалсан байна.

6. Орхон хонины үржлийн хуц 75-80 кг, эм хонь 58 кг жинтэй ноосны гарц 3,8-8 кг. Орхон хонины амьдын жин 102 кг, ноосны гарц 7 кг, урт нь 13 см хүрч байв. Өргөн урт шулуун хамар, өргөн цээжтэй, ноос бүх биеэр жигд ургасан, хондлой нь сэрвээнээсээ бага зэрэг өндөр, их биеэр өргөн хонь.

2010 оны байдлаар 1306.3 км<sup>2</sup> газар нутагтай, 2 багтай, 2.3 мянган хүн амтай, 677 өрхтэй, 23,2 мянган га тариалангийн талбайтай, 84.7 мянган малтай болжээ.

7. Орхоны САА-н хонин сүрэгт хийж байгаа үржлийн ажил болон, хонины ашиг шим үржлийн нарийн чанарыг тодорхой үзэсний үндсэнд 1960 онд “мах-ноосны” чиглэлийн нарийвтар ноост үүлдэр гэсэн нэртэйгээр баталжээ.

Шинэ үүлдрийн хонийг шалгах комиссын актад шинэ үүлдрийн хонийг Орхон үүлдрийн хонь гэдэг нэрээр БНМАУ-ын СнЗ-өөр баглуулж тус улсын хонин сүргийн үндсэн сайжруулагчийн нэгэнд ашиглах нь зүйтэй гэж үзсэн.

Орхон үүлдэлийг гаргасантай холбогдуулан оролцсон Б.Аюурзана, Ж.Рааш, Ш.Дашцэрэн нарт БНМАУ-ын төрийн шагнал, гар бие оролцсон Б.Аюуш Алтангадас одон, хоньчин Лувсан-Ишийг Сүхбаатарын одонгоор тус тус шагнажээ. Академич Т.Аюурзана 1943-1961 онд Орхон САА-д Монгол улсын анхны оюуны бүтээл болох мах ноосны чиглэлийн нарийвтар ноост “Орхон” үүлдрийн хонийг бий болгож, БНМАУ-ын шинэ бүтээлийн улсын бүртгэлд 1961.01.01-ны өдөр бүртгүүлж, Монгол улсын анхны Зохиогчийн эрхийн № 01 гэрчилгээ авч байжээ.

Орхон сумын Бэлэндалайн үтрэм дээр “Мартагдашгүй намар” киноны зураг авалт болсон түүхтэй.

8. Орхон үүлдрийн хонь, Ред. Ц.Арвий, Ж. Самбуугий нэрэмжит мал аж ахуйн хүрээлэн, УБ, 1978.

Сэлэнгэ нутаг(толь), О.Хишигсүрэн, УБ, 2003.

## **34. Баруунхараа**

1. Сэлэнгэ аймгийн Баянгол сум. Сумын төв нь Баянгол.
2. БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1931 оны 2-р сарын 7-ны өдрийн 5 дугаар тогтоолоор Богд хан уулын аймгийн Ноён уулын хошуунаас Төв аймгийн харьяалалд байгуулагджээ. 1933 онд 7 баг, 757 өрх, 2500 хүн, 67.3 мянган малтай байжээ. 1938 онд Сэлэнгэ аймагт шилжиж иржээ. Баянгол сумын “Мандах” нэгдэл 1939 онд байгуулагджээ. Сэлэнгэ аймаг Төв аймгийн харьяанд байхад 1956 онд Баянгол сумыг татан буулгаж, 1, 2, 3, 4-р багийг Зүүнхараад, 5-р багийг Дархан суманд

шилжүүлжээ. Баруунхараа САА нь 1957 онд анх үүсгэн байгуулагджээ. 1968 онд Баянгол сумын Мандах нэгдлийн татан буулгаж Баруунхараагийн САА-д нэгтгэсэн.

1972 онд ЗХУ-ын тусламжаар бүрэн ашиглалтанд орсон.

3. 1992 оноос олон жижиг компани болон хуваагдсан
4. Баруунхараа голын эрэгт оршино.
5. Сумын даргаар: Д.Содномжанцан, Гончиг, Чойжинням, Намчинжав, Л.Бадамсэд, Н.Цээрэн, Г.Хашбаатар, Ц.Гармаа, Л.Батжаргал, Р.Нямсүндэв, Х.Даваахүү /1992-2004/, М. Дэлгэрням /2004-2008/, Х.Даваахүү, Б.Энхбат /2008 оноос хойш/ нар ажиллажээ.  
Улсын аварга тариаланч Лхагва, Дашбямба нарын 20 гаруй хөдөлмөрийн сайчууд төрөн гарчээ.
6. Энд үр тариа хадгалан газар, малын тэжээлийн үйлдвэр, зам барилгын анги, нефтийн бүтгээгдэхүүн агуулах газар, төмөр замын буудалтай. 1965 онд “Мандах” нэгдэл 1917 мянган га нутаг, 695 гишүүн, нийгмийн өмчийн 32.9 мянган мал, 2.6 сая төгрөгийн мөнгөн орлого, 2.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байжээ.  
Баянгол сум 2010 оны байдлаар 1976.3 км<sup>2</sup> газар нутагтай, 3 багтай, 5.5 мянган хүн амтай, 1.6 мянган өрхтэй, 16,4 мянган га тариалангийн талбайтай, 130.7 мянган малтай болон өргөжжээ. Аймгийн төвөөс 170 км.
7. Сэлэнгэ аймгийн Баруунхараагийн САА-н бүрэн механикжсан саалийн ферм. Баянгол сум нь “Алатау” үүлдэрийн үхэр сүрэг үржүүлж өсгөсөн нутаг юм.  
Тус сумаас Хөдөлмөрийн баатар тариаланч Ч.Баяраа, хөдөлмөрийн баатар барилгачин Д.Жүгдэр, хөдөлмөрийн баатар жолооч М.Володя. гавьяат агрономч Түмэнбаяр, гавьяат эдийн засагч Л.Нямсамбуу, үйлчилгээний гавьяат ажилтан Ж.Бадраа, аж үйлдвэрийн гавьяат ажилтан Б.Нэргүй нарын алдартнууд төрөн гарчээ.
8. Сэлэнгийн түүхийн товчоон, Ө.Бавуу, Сүхбаатар хот, 2001.

### **35. Октябрь**

1. Төв аймгийн Сүмбэр сум.
2. 1976 оны 10 сарын 19 нд БНМАУ-ын СнЗ-ын тогтоолоор Жаргалантын САА-н Хар-Эрэг тасагт төвлөрүүлэн байгуулжээ.
3. 1992 онд хувьчлагдсан.
4. Жавхлант төвтэй.
5. Анхны дарга Баярын Норжин.
6. Байгуулагдсан жилдээ 7000 га-д үр тариа, үүнээс 5000 га-д улаан буудай, бусдад нь малын тэжээл, 600 га-д төмс тариалж, 6448 тонн төмс хураан авсан.

7. Анх байгуулагдахдаа 20 трактор, 5 машин, 14 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, 5.1 мянган га малтай, 10.8 га эргэлтийн талбайтай, 18 үндсэн ажилчинтай байгуулагджээ.

Дараа жилээс нь тариалах үрээ хадгалах механикжсан агуулахтай болж, нийслэл хотыг төмсөөр хангаад зогсохгүй ЗХУ-руу төмс гаргахад хувь нэмрээ оруулах болжээ.

8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдагва, УБ, 1998.

Төв аймгийн газар тариалан 50 жилд, М.Эрдэнэдалай ба Ж.Сүрэнхорлоо, Зуунмод, 2009.

### **36. Зүүнхараа**

1. Сэлэнгэ аймгийн Мандал сум. Сумын төв нь Хэрх.
2. 1922 онд Хараагийн Сангийн тариалан нэртэйгээр анх улсаас эрхлэн байгуулсанаар Монгол улсын САА-н түрүүч болсон юм. 1931-1932 оны үед зүүнтний алдаа завхарлын үед САА-д олноороо алдагдалтай ажилласан учир 1933 онд үйл ажиллагаа нь багассан. 1933 онд 10 баг, 891 өрх, 2800 хүн, 56.3 мянган малтай байжээ. Мандал сумын “Цэцэрлэг” нэгдэл 1956 онд үүсчээ. Мандал сум 1938 онд Сэлэнгэ аймагт шилжиж иржээ. БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1941 оны 2-р сарын 11-ний өдрийн 81 дүгээр тогтоолоор Төв аймагт буцааж шилжүүлжээ. 1943 онд татан буулгаж, Батсүмбэр, Угтаал-Цайдам сумдад нийлүүлсэн байна. 1960 онд буцаж Сэлэнгэ аймагт ирсний дараа БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1961 оны 1-р сарын 9-ний өдрийн 7 дугаар Зарлигаар Зүүнхарааг хот болгож, хотын захиргааг байгуулжээ. Улмаар БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1968 оны 1-р сарын 13-ны өдрийн 9 дүгээр Зарлигаар Мандал сумыг Зүүнхараагийн САА-г харьяалсан сум болгож, тус сумын төвийг Зүүнхараад шилжүүлжээ. Мөн сумын “Цэцэрлэг” нэгдэл САА-д нийлжээ. 1976 онд Орхон-Туулын САА-н Номгон тасгийг түшиглүүлэн байгуулжээ.
3. 1992 онд хувьчлагдсан. Монгол Улсын Их Хурлын 1994 оны 5-р сарын 6-ны өдрийн 36 дугаар тогтоолоор Сэлэнгэ аймгийн Зүүнхараа хотыг Мандал суманд нэгтгэн Мандал сум гэж нэрлэжээ.
4. Зүүн хараагийн голын ойролцоо.
5. Сумын даргаар: Б.Цогтзанаа, Хүрлээ, Д.Дарамжав, Д.Цэдэв, Ж.Жавзандорж, О.Дорлигсүрэн /1992-1996/, Х.Дүнгээ, Я.Жигжид /1996-2000/, Х.Дүнгээ /2000-2004/, Б.Цээпилдорж /2004 оноос одоог хүртэл/ нар ажиллажээ. БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар, алдарт гахайчин Ц.Буниа, 1981 онд Сэлэнгэ аймгийн Зүүнхараагийн САА-н тэргүүний гахайчин хошой аврага Дэнсмаа нар ажиллаж байв. 1986 онд үхэрчин Т.Дагва Хөдөлмөрийн

баатар цол хүртсэн.

6. Хараагийн САА-н тарьсан ба хагалж боловсруулсан талбай. (талбай десятинаар)

	1924 он	1925 он	1926 он	1927 он	1928 он	1929 он
Тарьсан	600	700	800	1370	2249	2356
Хагалсан	150	150	200	677.5	896.5	1770

1965 онд 418.6 мянган га нутаг, 687 гишүүн, нийгмийн өмчийн 24.7 мянган мал, 1.4 сая төгрөгийн мөнгөн орлого, 1.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байжээ.

1992 оны байдлаар 2521 хүнтэй мод бэлтгэлийн аж ахуй, ардын цэргийн анги, төмөр замын өртөө, 10 жилийн дунд сургууль, их эмчийн салбар, амины болон аж ахуйн нэгжийн 6000 шахам толгой малтай байжээ. Аймгийн төвөөс 240 км, зэргэлдээх сумын төвөөс 40 шахам км алслагджээ. Гол үйлдвэрлэл нь мод бэлтгэл бөгөөд цаашид боловсруулах үйлдвэрлэл, байгалийн баялаг, алт олзворлох ажлыг хийж байгалийн гоо үзэсгэлэнт нутгийг ашиглан аялал жуулчлал хөгжүүлэх өргөн боломжтой. Түнхэл хорооны төвөөс зүүн ба зүүн урд чиглэлд Хэнтий нурууны битүү хөвч ой тайга үргэлжлэх бөгөөд энэ чиглэлд Түнхэлийн төвөөс 100 гаруй км авто зам тавьж, мод бэлтгэлийн үйлдвэрлэл явуулж байв.

7. 1937 онд хоригдол хүмүүсийн хүчийг САА-н үйлдвэрлэлд ашиглах зорилгоор Хараагийн Сангийн Аж Ахуйг Мал Тариалангийн яамнаас Дотоод яамны мэдэлд шилжүүлж, 1933-1935 онд улсаас зээлдүүлсэн 263117 төгрөгийг эргүүлэн төлүүлэхээр тогтоож байжээ. Газар тариалан, МАА-н үйлдвэрлэл, алтны үндсэн ордын олборлолтын үйлдвэртэй. Зүүнхараагийн Спирт бал бурмын үйлдвэр, төмөр замын өртөө, дэр модны үйлдвэртэй, Хэрх, Түнхэл тосгонтой. Зүүнхараа хотод 1952 онд Зүүнхараагийн Төмөр замын станцыг түшиглэсэн 4 хороотой захиргаа байгуулагджээ.
8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдагва, УБ, 1998.

### 37. Баянчандмань

1. Төв аймгийн Баянчандмань сум.
2. 1958 онд Хөдөө аж ахуйн машин засварын газар нэртэйгээр анх байгуулагдажээ.  
1979 онд цэрэг армийн хэрэгцээг хангах зорилгоор анх байгуулжээ.
3. 1992 онд хувьчилагдсан.
- 4.
5. Сангийн аж ахуйг дахин байгуулагдахад даргаар нь Самданхүү гэдэг хүн

ажиллаж байжээ.

- 6.
7. 1963 онд төвийн хэсгийг нь хороо захиргаа байгуулж, ихэнх багуудыг нь Борнуурын сангийн аж ахуйд шилжүүлжээ. 1981 оноос эрдэм шинжилгээний туршилгын бааз сангийн аж ахуй болгожээ.
8. Төв нутгийн хүмүүн шастир, Л.Хэнчяахав, УБ, 2008.

### **38. Жаргалант**

1. Төв аймгийн Жаргалант сум.
2. Тус сум 1929 онд албан ёсоор Жаргалантын САА нэртэйгээр байгуулагджээ. 1931-1932 оны зүүнтний алдаа завхарлын үед САА-д олноороо алдагдалтай ажилласан учир 1933 онд татан буугджээ. 1957онд БНМАУ-ын АИХТ-ийн зарлигаар Төв аймгийн Жаргалант сумын САА байгуулагдсанаар газар тариалангийн үйлдвэрлэлийг голлосон, бие даасан том АА бий болжээ. 1945 он хүртэл сангийн аж ахуйн трестэд харъяалагдан захирагдаж 1945 оноос мал тариалангийн яаманд харъяалагдаж байжээ.
3. Мөн 1976 онд Жаргалантын САА-гаас Октябрь САА тасран салж, 1991оны өмч хувьчлалаар 3 ХК, 1 ХХК болон олон арван хоршоо, ХЭАА бий болжээ. Гол ХХК нь Арцаг, Жаргалант гэдэг нэртэй байгаад 1996 он хүртэл үйл ажиллагаагаа явуулж байгаад хувийн ХХК болсон байна.
4. Төв аймгийн Жаргалант сум Хараа голоос баруун урагш Жаргалант, Угтаал, Агьт, Загдал, Зөөхийн хөндийг хамарсан 242000 орчим га газрын хамарсан өргөн уудам нутгийг эзлэдэг.
5. 1939 оноос Сангийн аж ахуйн даргаар Дамба, Өлзий, Даваажав, Тунсаг, Цэрэн-Очир, Пүрвээ, Сосорбарам, Н.Аръяа нар сонгогдож улмаар Н. Аръяа нь 1970-аад онд хөдөлмөрийн баатар болжээ. Монгол улсын газар тариалангийн анхны хөдөлмөрийн баатар тракторч, камбайнч, ХААИС-ын багш Цэрэн-Очир болжээ. Намын хорооны нарийн бичгийн дарга Н.Дашням, САА-н намын байгууллагын удирдах ажилтан нарын дундаас “БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар” цолыг анх хүртсэн.
6. 1945 онд ЗХУ-ын тусламжтайгаар газар хагалах, үр тариа хураах, цайруулах, хүнд хүчир ажлыг механикжуулах, трактор, комбайн, цэвэрлэгч машинтай болж, 7000 орчим га атар газар хагалан эзэмшижээ. 1960-аад оноос 532 га талбайн усалгааны систем байгуулж, жимс жимсгэний АА-г хөгжүүлж, 1970-аад оны үеийн Жаргалантын САА оргил үедээ 46.0 мянган га эргэлтийн талбайтай, жилдээ 30.5 мянган га-д үр тариа, 300 га-д төмс 100 га-д хүнсний ногоо, 1200 га-д малын тэжээл, 40 га-д жимс жимсгэнэ тус тус тариалж, 10.0 мянган тонн хадлан бэлтгэдэг, 40.0 мянган хонь, 1000-аад адуу, 4.0 мянга шахам үхэр, 400-2.0 мянган үнээний

Сүүний механикжсан ферм, 35.0 мянган өндөглөгч тахиа, 100 үндсэн 50 ээлжийн мэгж бүхий гахайн ферм, 170 трактор засварын 3-н газар 70 орчим автомашин бүхий авто граж зэрэг бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулж иржээ.

1960-1970 онуудад САА-н хөгжил эрчимжиж бүтээгдэхүүн 3 дахин нэмэгдсэн, одоо САА нь 44000 га эргэлтийн талбайтай жил тутам 30 гаруй мянган га газарт үр тариа, төмс, хүнсний ногоо малын тэжээлийн ургамал, жимс тариалж байв. Газар тариалангийн ажил бүрэн механикжжээ.

7. 1954 онд Жаргалант САА-н дэргэд Жаргалант сумыг байгуулжээ. Тус САА-аас Баруунхараа, Сүмбэрийн САА-ууд бие дааж гарсан түүхтэй. 1940-өөд оноос газар тариаланг МАА-н салбартай хослуулан хөгжүүлэх зорилгоор нарийн нарийвтар ноост хонь, мах сүүний чиглэлийн цэвэр үүлдэрийн үхэр, шилмэл удмын адуун сүргийг хөгжүүлэхэд онцлон анхаарч ирсэнээр газар тариалан, эрчимжсэн МАА-г хөгжүүлэхэд өндөр амжилт бүтээл гаргаж байсныг нь төр засгаас үнэлэж, 1941 онд “Хөдөлмөрийн гавьяаны улаан туг”-ийн одонгоор шагнасан. Мөн засгийн газрын жуух бичгээр 6 удаа шагнагдав.
8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдагва, УБ, 1998.  
Сэлэнгийн түүхийн товчоо, Ө.Бавуу, Сүхбаатар, 2001.

### 39. Борнуур

1. Төв аймгийн Борнуур сум.
2. Анх хэдэн онд байгуулагдсан нь тодорхойгүй байдаг ч 1927 оны мэдээгээр Борнуурын Улсын аж ахуйн үйл ажиллагааны талаар мэдээ сурвалж байдаг. 1931-1932 оны үед зүүнтний алдаа завхарлын үед САА-д олноороо алдагдалтай ажилласан учир 1933 онд татан буугджээ. 1959 онд Улсын бага хурлын тэргүүлэгчдийн зарлигаар Бат-Өлзийт сумаар Борнуурын САА-сумыг байгуулсан.  
1931 он Батсүмбэр сум  
1938 он Баян-Өлзийт сум  
1951 он Баянчандмань сум  
1959 он Борнуур сум
3. 1991 он Борнуур сангийн аж ахуй нь Борнуур хувьцаат компани, Шархоолой, Даваанбулаг, Мандалнаран компаниуд болон хувьчлагдсан.
4. Шархоолой.
5. Д.Нандинцэцэг 1955 онд эрлийз үнээ бүрээс 1700 литр сүү сааль, Б.Лхагва 1977 онд 28 үнээнээс 29 тугал бойжуулж, БНМАУ-ын залуу аварга малчин болжээ. Саальчин Маахүүгийн Чимгээд 1983 онд үнээ бүрээсээ 5936 литр сүү бүгд 148600 литр сүү саан БНМАУ-ын хөдөлмөрийн баатар болжээ.

6. Борнуур улсын аж ахуй нь 700 десятин тариалж, 500 десятин пар хагалсан. 1976 онд Герман улсаас сүүний үүлдэрийн 1200 хар тарлан гунж авч, байршуулсан.
7. 1962 оноос Баянчандмань дахь “Эрнест Тельман” -ны Замтын нэгдлийг тус сангийн аж ахуйтай нэгтгэснээр цаашид хөгжсөн байна. Улмаар БНАГУ-ын техник технологиор Герман мэргэжилтэнүүдтэй хамтран ажиллаж, Улаанбаатар хотыг хангах төмс хүнсний ногооны 20 гаруй хувийг үйлдвэрлэдэг, хар тарлан үүлдрийн 400,800 үнээ, 720 гунжийн механикжсан зоорь, 3500 тонн хорголжин тэжээл үйлдвэрлэх цех, 7200 ам метр талбай бүхий шилэн хүлэмжтэй, төр олон нийт эмнэлэг сургууль, үйлдвэр үйлчилгээний байгууллага бүхий томоохон аж ахуй болон хөгжиж төвлөрсөн юм. Борнуурын САА 70.0 га бэлчээрийн талбайд МАА-гаа эрхлэдэг байв. V, VI таван жилийн төлөвлөгөөнд механикжсан саалын үнээ, 400-800 үнээний фермийг ашиглалтанд оруулсан. 1973, 1975, 1984 онуудад төмс хүнсний ногооны ургацаар МХЗЭ-ийн Төв Хороо, ХААЯ, НхДЗ-ийн зарласан болзолт уралдаанд 1, 2-р байр эзэлж, 20-60 мянган төгрөгөөр тус тус шагнуулж байжээ. БНАГУ-ын “Астелла” сортын төмсийг Монгол нутагт нутагшуулан тариалж, тогтвортой ургац хураан амжилт гаргасан хамт олон улсын 10 удаагийн аврага бригад болсон түүхтэй. Монгол улсын хэмжээнд хамгийн томоохон 1100 га усалтын системийг түшиглэн төрөл бүрийн ногоог тарьж, 4000 тн төмсний механикжсан агуулахад хадгалахыг нь хадгалж, борлуулахыг нь борлуулж, бас 3500 тн хорголжин тэжээл үйлдвэрлэж 7200 м<sup>2</sup> эрт ургацын ногоо болон үрслэг бойжуулах шилэн хүлэмжиндээ тарих, байцааны Бельрусс-85 сорт, Шийр-6 зэрэг олон төрлийн ногоо аль эрт болдог байв. 1983 онд герман улсын тусламжтайгаар шилэн хүлэмж баригдаж, 1984 онд 13 ажилчинтайгаар тариалалтаа эхлэж эрт ургацын ногоо, байцаа, өргөст хэмх улаан лооль, чинжүү, сонгино зэрэг нарийн ногоо тариалж улсаас өгсөн төлөвлөгөөг давуулан биелүүлж ирсэн.
8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдагва, УБ, 1998.  
Төв аймгийн газар тариалан 50 жилд, М.Эрдэнэдалай ба Ж.Сүрэнхорлоо, Зуунмод, 2009.  
Заяа түшсэн нутаг, Л.Хэнчяахав, Б.Галбадрах, Л.Лосол, УБ, 2008.

#### **40. Батсүмбэр**

1. Төв аймгийн Батсүмбэр сум.
2. 1931 оны 2 сарын 7-ны өдрийн Улсын Бага хурлын тэргүүлэгчдийн 5-р тогтоолоор Богд хан уулын аймгийн Ноён уулын хошуунаас байгуулагдсан. 1930-иад оны Зүүнтний алдаа завхарлын үед САА алдагдалд орж ихээхэн

өр төлбөрт унасан учир үйл ажиллагаа нь багасан, туршилтын журмаар үр тариа тарих болсон. 1953 онд дахин байгуулагдсан.

3. 1956 онд татан буулгаж, 1959 онд дахин сум, САА болгосон.
4. Сөгнөгөр, Жаргалант, Үдлэг, Баян толгой, Улаантолгой.
5. 1963 онд Д.Дарамжав тус САА-н даргаар ажиллаж байсан. 1961 онд БНМАУ-ын анхны хөдөлмөрийн баатар болсон ногоочин Д.Долгор, 1971 онд БНМАУ-ын хөдөлмөрийн баатар С.Равжаа гахайчин, 1981 онд Хөдөлмөрийн баатар болсон саальчин Ц.Хорлоо нар тус тус ажиллаж байв.
6. Га тутмаас хураасан ургац 1980 онд үр тариа 8.0, буудай, төмс 77.6, хүнсний ногоо 167.9, тэжээл бүгд 36.0, бүгд дарш 47.9  
1984 онд үр тариа 6.8, төмс 171.8, тэжээл 111.8, хүнсний ногоо 107.6, тэжээл бүгд 118.8, бүгд дарш 134.5  
300 га-д төмс, 300-д хүнсний ногоо тариалдаг байжээ.  
400 үнээний 2, 800 үнээний 1 фермтэй, жил тутам 5 сая орчим литр сүү үйлдвэрлэн, 4000 га-д тариалалт явуулан, жилдээ 4 сая гаруй литр сүү, 8000 тонн төмс, хүнсний ногоо улсад тушааж, 15-17 сая орчим борлуулт хийдэг.  
Газар тариалангийн салбар нь 1000 гаруй га талбайтайгаас 2500 гаруй га-д тэжээлийн үр тариа бусад ургамал, 600 га-д төмс, хүнсний ногоо тариалж байв.
7. 1933 онд Батсүмбэрийн САА нь нийслэлийн хөдөлмөрчдийг сүүгээр болон хүнсний ногоогоор хангах чиглэлтэй 7 баг 657 өрх, 2100 хүн, 48,9 мянган малтай, 100 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй байжээ.
8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдагва, УБ, 1998.  
Төв аймгийн түүхэн товчоон, Б.Дашзэвэг ба бусад, УБ, 2003.  
Төв аймгийн газар тариалан 50 жилд, М.Эрдэнэдалай, Ж.Сүрэнхорлоо, Зуунмод, 2009.

#### 41. Залуучууд

1. Төв аймгийн Цээл сум.
2. БНМАУ-ын СнЗ-ийн 1976 оны 10 сарын 19 ны өдрийн 356-р тогтоолоор байгуулжээ.
3. 1990 оноос хэдэн хэсэг болон хувьчлагдсан.
4. Оргил төвтэй.
5. Анхны даргаар Хөдөлмөрийн баатар Бэгзийн Батчулуун, агрономич Д.Дамдинсүрэн, инженер Д.Цагаан, ерөнхий нягтлан бодогч Сосорбарам нар удирдан ажиллуулж эхэлжээ.
6. Газар тариалангийн үйлдвэрлэлд Дарханы ургамал газар тариалангийн



эрдэм шинжилгээний хүрээлэн, ЗХУ-ын өндөр мэргэжлийн мэргэжилтэнүүдийн группыг урин ажиллуулж, ЗХУ-ын өндөр хүчин чадалтай Т-150 трактор, хөрсний эвдрэлээс хамгаалах газрын хаван боловсруулах техник, КПЭ-3.8, КПШ-5, КПШ-9, СЗС-2.1, СЗС-3.6 үрлэгч, Биг-3, КПП-250 зэргийн тоног төхөөрөмж ашиглах, хөрс хамгаалах иж бүрэн төхөөрөмж газар тариаланд шинээр нэвтэрүүлж, 26-42 центнер ургац хураан үр дүнтэй ажиллаж байлаа.

7. 1976 онд Угтаалын САА-н Цээлийн тасгийг түшиглүүлэн үр тариа болон нарийвтар ноост хонь үржүүлэн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар байгуулжээ. Тус САА шинэ технологийг нэвтрүүлж, эрчимжсэн технологээр 26-42 центнер ургац хурааж байжээ.
8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдагва, УБ, 1998.  
Төв аймгийн газар тариалан 50 жилд, М.Эрдэнэдалай ба Ж.Сүрэнхорлоо, Зуунмод, 2009.

## 42. Угтаал

1. Төв аймгийн Угтаалцайдам сум.
2. Анх 1925-1930 оны хооронд Халиугчин Боролзой уулын хошуунд багтаж байгаад 1938 оноос Тээл, Буга, Уушигийн ухаа, Шийр зэрэг газраар нүүдэллэж байгаад Уушигийн ар Номгоны өвөрт суурьшсан байна. 1936-1937 онд Зөвлөлт Холбоот улсын тусламжаар манай улсад анх байгуулагдсан машинаар өвс хадах 12 станцийн нэг нь тус суманд байгуулагджээ. 1944 онд Цөцгийн тос боловсруулах завод байгуулагдан түүний даргаар Н. Гомбосүрэн ажиллаж байв.  
1959 онд МАХН-ын IX бүгд хурлын шийдвэрийн дагуу, 1961 оны 3 сарын 27 нд тус суманд атарын анхны аяны дагуу уг САА байгуулагдсан.
3. Тус САА 1980-аад оныг хүртэл их эрчимтэй ажиллаж байсан ч 1990-ээд оноос ажиллаж байсан бүрэлдэхүүн нь салахад үйл ажиллагаа нь муудаж, одоо зөвхөн Угтаалцайдам сум нэртэй болсон. 1991 онд тус Сангийн аж ахуйгаас “Угтаал” хувьцаат ХХК байгуулагдаж, ерөнхий захирлаар нь тус аж ахуйн ерөнхий агрономичоор олон жил ажилласан Г.Магвандорж ажиллаж байжээ. 1993 оноос 4 компани, 9 хоршоо, 46 ХЭАА болж үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх болжээ.
4. Сумын баруун зүүн захын Угтаал уул, Цайдам нуур хоёрын нэрийг нийлүүлж өгсөн.
5. Атарын анхны аяны хүрээнд тус САА-д анх 76 хүн очсон нь гавъяатай хүмүүс байсан юм. Эндээс анхны дарга нь Бэгзийн Батчулуун төрөн гарч, ажил үйлсээрээ шалгарсан тул 1975 онд БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар болж байжээ. Мөн атарчдын алтан медалиар тариаланч Ж.Мөнхтоогоо

шагнагдсан.

Тракторч, комбайнч Г.Алтанхүү “БНМАУ-ын хөдөлмөрийн баатар” болсон.

6. 167.3 мянган км хавтгай нутагтай, 143.3 мянган га ХАА-н эдэлбэр газартай, сумын иргэд болон атарчид нийлсэн 4000-аад хүнтэй байлаа. Эхний жилдээ 15.0 мянган га газар эзэмшиж, Угтаалын САА анхны жилдээ 1-га-гаас 15 центер ургац авч, 1962 онд авсан ургацаараа улсад тэргүүлж, НТХ, СнЗ-аас шилжин явах улаан туг, 30.0 мянган төгрөгөөр, улсад тушаах үр тарианы төлөвлөгөөг САА-г удирдах газрын болзлоос давуулан биелүүлсэн тул БНМАУ-ын СнЗ-ийн Хүндэт жуух бичиг 150.000 төгрөгөөр шагнагдаж байлаа. 1970-аад он болоход тус аж ахуй анх 40 орчим мянган ам дөрвөлжин километр эргэлтийн талбайтай болжээ. Мөн аж ахуй 48,2 мянган эргэлтийн талбайтай 33000 га газар тариа, 60 шахам мянган малтай, жилдээ багсармал тэжээл, байгалийн хадлан 21-22000 тонн бэлтгэж 25-27 сая төгрөгийн нийт бүтээгдэхүүн, 22-24 сая төгрөгийн таваарын бүтээгдэхүүн үйлдвэрлэж 5-6 сая төгрөгийн ашигтай ажиллаж байжээ. Байгуулагдснаасаа хойших 15 жилд 349,3 мянган тонн үр тариа хураах төлөвлөгөөг 370,9 мянган тонн буюу 106,4 хувь биелүүлж, 18936 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 54,3 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. 5 Жилд 39,8 мянган тонн үр тариа илүү хурааж улсад 18,2 мянган тонн үр тариаг төлөвлөгөөнөөс давуулж 115,7 тэмс, 214 хувь хүнсний ногоог 110 хувь биелүүлжээ. Мал өсгөх хөдөлшгүй төлөвлөгөөг сангийн аж ахуй 3 жилд сумаараа 2 жилийн өмнө 5 төрөл дээр нь 122 хувь буюу 11000 малаар давуулж түүнээс тэмээг 109,5 хувь, үхэр 124,7 хувь, адуу 124 хувиар тус тус биелүүлсэн.
7. Тариалан эрхлэх төдийгүй тэжээлийн үйлдвэр, хүнсний ногоо, хадлан тэжээл бэлтгэх зэргээр өргөжүүлэн хөгжүүлсэн. Үр тарианы үйлдвэрлэл голлож байх үедээ өндөр ургац авч байсан жилүүд нь 1960-аад онууд, 1973-1975 онууд байсан бөгөөд 1 га газраас 18-20 центнер ургац хурааж, улс аймагтаа 4-6 удаа түрүүлж байв. Сангийн аж ахуйн дэргэд тэжээлийн үйлдвэр ажиллаж, жилдээ хэдэн зуун тонн багсармал тэжээл бэлтгэж байжээ. 1960-аад оноос тус сумын нутагт хэд хэдэн САА байгуулагдаж эхэлсэн байна. Залуучуудын САА, Жаргалантын САА, Атар, Октябрь, Баянцогтын САА-нууд зэргийг дурдаж болно.
8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдагва, УБ, 1998. Төв аймгийн газар тариалан 50 жилд, М.Эрдэнэдалай, Ж.Сүрэнхорлоо, Зуунмод, 2009.

### 43. Баянцогт

1. Төв аймгийн Баянцогт сум.
2. Анх 1929 онд Өвөр дулаан гэдэг газар байгуулагдаж анхны даргаа нь Чүлтэм бичээч ажиллаж байв. Улмаар 1931 оны 3-р сард хошуу тамгуудыг татан буулгаж сум аймагтай харилцах шууд эрхтэй болжээ. 1958 онд Баянцогт сум дахин байгуулагдаж, 1959 оны 3 сард хуралдсан МАХН-ын ТХ-ны III бүгд хурлын тогтоолоор эх орны гурилын хэрэгцээг дотроосоо хангах зорилгоор атар газар эзэмших шийдвэр гаргасны дагуу байгуулагдсан. 1962 онд Баянцогтын САА албан ёсоор байгуулсан.
3. 1990-ээд онд хувьчлагдсан.
4. Гуна, Хонгорын хөндий.
5. Чүлтэм /1929-1931/, Дорж /1931-1935/, Нарангэрэл /1935-1936/, Намсрай /1936-1938/, Пүрэвжав /1938-1939/, Цог /1939-1941/, Палам /1941-1942/, Сундуй /1942-1945/, Базаррагчаа /1945-1946/, Чагнаа /1946-1947/, Жанчив /1947-1948/, Ринчин /1948-1952/, Дэмбэрэл /1952/, Дондогдорж /1952-1954/, Жамбаа /1954-1956/, Чойжилсүрэн /1958-1959/, Палам /1959/, Дашням /1959-1961/, Ишжамц /1961-1962/, Дашзэвэг /1962/ анхны үеийн даргаар ажиллаж байсан.  
1986 онд Хөдөлмөрийн баатар, саальчин П.Оюун, Анхдагч Б. Сүрэнхорлоо Гуны бригадын дарга, Б. Наянтай тракторч, Г. Будёнин, Д. Очир, Д. Пэрэнлэй, Нордогжав.
6. 1962 оны 4 сард тус нэгдлийг Сангийн аж ахуйтай нийлүүлэхэд тэмээ 348, адуу 7026, үхэр 2510, хонь 27621, ямаа 6165, бүгд 43670 мал байсан. Анх 1961 оны 2 сарын 29-нд Дунд уртын хуучин хятад тариачид байсан нурсан балгасны суурин дээр 2 гэр, 3 машин, 20 гаруй залуучуудтай анх атар газар эзэмших зорилгоор байгуулагдсан байна. Улмаар 1970-аад он болоход энэ сум сангийн аж ахуй 291,0 мянган га газар нутагтай, үүнээс бүх бэлчээр 224,1 мянган га-гийн хадлангийн бүх талбай 7,0 мянган га, ой, тайга 9,9 мянган га тариаланд шинжлэгдсэн 50,0 мянган га газар нутагтай энэ оны байдлаар тус сум сангийн аж ахуйд 700 гаруй өрх, 2600 шахам хүн амаас хөдөлмөрийн чадвартай 1500 хүнтэй үүнээс комбайнч-тракторчид 200 шахам, малчид 300 гаруй бусад ажилчин, ажилчид 100 гаруй барилга рам, мод гуалинд тогтмол 20 гаруй хүн ажиллах хүчтэй болсон байв. 1962 онд хүлээн авсан төлөвлөгөөг 178 % -аар биелүүлж улсад 1-р байр эзлэн 50 мянган төгрөг, 1963 оны аж ахуй соёлын төлөвлөгөөт арга хэмжээг аймагтаа тэргүүлсэн байна.
7. Симменталь, Алатау зэргийн сүү махын үүлдрийн үхрийг цэврээр буюу эрлийзжүүлэх замаар үржүүлж байсан.
8. БНМАУ-ын Хөдөө аж ахуй 60 жилд, Т.Бямбаа, УБ, 1982.  
Төв аймгийн газар тариалан 50 жилд, М.Эрдэнэдалай, Ж.Сүрэнхорлоо,

Зуунмод, 2009.

#### 44. Партизан

1. Улаанбаатар хот.
2. 1976 онд байгуулагдсан.
3. 1992 онд татан буугдаж Улаанбаатар хотын Сонгино хайрхан дүүргийн Жаргалант тосгон болсон.
4. 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалуудын Партизануудын нэрэмжит болгосон.
- 5.
6. Жилдээ 7 сая литр сүү сааж улсад нийлүүлдэг байсан. 800 үнээний механикжсан үнээний 2 ферм, 400 үнээний ферм 1, 200 үнээтэй энгийн бригад ажиллаж байсан.
7. Улаанбаатар хотын хүн амын ихэнхийн сүүгээр хангадаг байжээ.
- 8.

#### 45. Гачуурт

1. Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо-Гачуурт тосгон.
2. Гачууртын Сангийн Аж ахуй нь 1961 оны 4 сарын 19-нд Сайд нарын Зөвлөлийн 181-р тогтоолоор Төв аймгийн Баянзүрх сум (*Хожим Эрдэнэ сум*)-ын Улиастай, Дархит, Хуандайн фермүүдийг түшиглэн Улаанбаатар хотыг сүү цагаан идээгээр хангах зорилгоор 1340 малтай, далаад ажилтантай байгуулагдсан байна.
3. 1993 онд татан буугдаж хувьчлагдсан.
4. Гачуурт хэмээх газар нь Улаанбаатар хотоос 21 км орших бөгөөд Баянзүрх Хайрханы ард, Туул голын хөвөөнд Цагаан эргийн дэнж, Алтан тэвшийн хөндийд орших жижиг голын нэр болно.
5. Монгол улсын Хөдөлмөрийн баатар Галдангийн Зина 1971 онд тус Сангийн аж ахуйгаас хөдөлмөрийн баатар болсон.
6. Энэ сангийн аж ахуй нь 1958-1959 онуудад Зөвлөлт Холбоот улсаас авчирсан семминталь, хар тарлан үүлдрийн үхэртэй байсан бөгөөд Улаанбаатар хотын зүүн хойно байх Дамбадаржаагийн Вьетнамын нэрэмжит Чойбалсангийн зам нэгдлийг 1962 онд Гачууртад нэгтгэсэн байна. 1976 онд 131,5 мянган га нутаг дэвсгэртэй, 13089 толгой малтай, 806 ажилтантай, 45,2 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй жилдээ 8,8 сая төгрөгийн мөнгөн орлоготой, сүүний арван фермтэй, үүний дотор 800 үнээний саалийн механикжсан ферм, 1400 үнээний СФМ-1, СЭФ-8 ажиллаж сүүний чиглэлээр төрөлжсөн томоохон Сангийн аж ахуй байв.
7. Улаанбаатар хотын ард иргэдийг сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангах зорилготой хамгийн ойрхон орших Сангийн аж ахуй байв.

8. Төв нутгийн хүмүүн шастир, Эмхэтгэсэн Л. Хэнчяахав, УБ, 2008.

#### **46. Атар**

1. Төв аймгийн Баянхангай сум.
2. БНМАУ-ын СнЗ-ийн 1976 оны 10 сарын 19 ны өдрийн 356-р тогтоолоор байгуулжээ.
- 3.
4. Атарын анхдугаар аяны газар хагалж байсан газар. Төв нь Баянхангай.
5. Анхны дарга Сүрэнжавын Тамжид, Даваацэрэнгийн Доржпалам, Нанзадын Уртнасан, Жамбын Нямдаваа, Лхагвагэндэнгийн Бямбасүрэн, Юмжаагийн Алтансүх.
6. 1986 онд ажлаараа аймагтаа тэргүүн байр, ҮШ таван жилийн эхний дөрвөн жилд мал өсгөх, хадлан тэжтээл бэлтгэх, үр тариа, төмс хүнсний ногоо хураах, улсад тушаах төлөвлөгөөг 100-140%-иар амжилттай биелүүлж байжээ.  
Га тутмаас хураасан ургац 1980 онд үр тариа 2.0, буудай 3.6, төмс 40.0, хүнсний ногоо 90.0, тэжээл бүгд 15.0  
1984 онд төмс 190.0, хүнсний ногоо 21.0, тэжээл бүгд 31.5, бүгд дарш 103.2.
7. 1977 онд Лүн сумын нутагт үр тариа, махны чиглэлийн мал үржүүлэх зорилгоор анх байгуулжээ. Атарын II аян улс орон даяар өрнөж, 10 САА-г шинээр байгуулсан нь Атар САА байлаа.
8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдагва, УБ, 1998.  
Баянхангай нутаг сум-САА байгуулагдсаны 30 жилийн ойд зориулав. Д.Оюунчимэг, Улаанхад, 2007.  
Төв аймгийн түүхэн товчоон, Б.Дашзэвэг ба бусад, УБ, 2003.  
Төв аймгийн газар тариалан 50 жилд, М.Эрдэнэдалай, Ж.Сүрэнхорлоо, Зуунмод, 2009.

#### **47. Нөхөрлөл**

1. Төв аймгийн Аргалант сум.
2. 1976 оны 10 сарын 19 нд Баянцогт суманд байгуулжээ.
3. 1990-ээд оноос Нөхөрлөл САА-г төрийн өмч давамгайлсан Нөхөрлөл ХК болгосон.
4. Аргалант.
5. Анхны дарга нь 1976 онд инженер мэргэжилтэй Бадамдоогийн Дамдинсүрэн томилогджээ. 1987 оноос Д.Санжмятав тус тус ажиллаж байжээ.
6. 1991-1997 онд сумын төсөвт 21.0-53.0 сая төгрөгийн татвар, Нийгмийн

даатгалын санд 16.0-26.0 сая төгрөгийн шимтгэл төлсөн байна.

7. Үр тариа, МАА-н чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. 1977 онд Нөхөрлөл САА-д түшиглэн Аргалант сумыг байгуулжээ. 1990-ээд оноос САА-г ногоо тэжээл голлон тариалдаг байсныг өөрчилж, улаан буудай, үр тариа төмс, арвайн гурил, хивс, дархан, худалдаа, мухлаг зэргийг эрхлэх болгож 200 гаруй хүний ажилчидтай, ажиллаж байв.
8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдавга, УБ, 1998 он.  
“Аргалантыхан” дурсамж, дурдатгал эмхтгэсэн Б.Дамдинсүрэн, Б.Хүүхэнбаатар, Б.Базар-Адъяа ба Б.Магсаржав, УБ, 2007.  
Төв аймгийн газар тариалан 50 жилд, М.Эрдэнэдалай, Ж.Сүрэнхорлоо, Зуунмод, 2009.

#### 48. Архуст

1. Төв аймгийн Архуст сум.
2. 1969 онд анх мал аж ахуйн чиглэлээр байгуулагдсан.
3. 1991 он.
4. Шунхлайн ухаа, Бөөрөлжүүтийн хөндий.
5. Сургууль комбинатын анхны төгсөгч Паламын Даржаа, Батсүхийн Авирмэд, Аюурын Доржсүрэн, Тавхайн Рэнцэн нарын 20 гаран залуус Шунхлайн ухаад 500 га атар хагалснаар анхдагч нь болдог.
6. Архустын сангийн аж ахуйн тариалангийн эргэлтийн талбай нь 1969 оны байдлаар буюу атрын I аяны хүрээнд 10 гаруй мянган гектар болж үр тарианаас гадна эрдэнэшиш, вандуй, төмс зэрэг хүнсний ногоо тариалж байжээ.
7. 1955 онд Архустын сангийн аж ахуйг түшиглүүлэн тракторч, комбайнчдыг сургах сургууль комбинатыг мөн байгуулсан байна. Тус САА-н үйлдвэрлэлийн нэг үндсэн салбар нь тариалангийн салбар байсан бөгөөд мэргэжилтнээ өөрсдөө бэлдэж, ажлуулж байжээ. 1974 онд Архуст сумыг Эрдэнэ сумтай нэгтгэхэд САА-н малыг Эрдэнэ сумын Монгол-Унгарын найрамдал нэгдэлд шилжүүлжээ.
8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдавга, УБ, 1998.  
Төв аймгийн газар тариалан 50 жилд, М.Эрдэнэдалай, Ж.Сүрэнхорлоо, Зуунмод, 2009.

#### 49. Хэрлэн-Баян-улаан

1. Хэнтий аймгийн Дэлгэрхаан сум.
2. 1974 онд “Хэрлэн-Баян-улаан отор тэжээлийн станц” нэртэйгээр байгуулжээ.

3. 1992 онд хувчлагдсан.
4. Хэрлэн голын зүүн биед орших 1000 өвөлжөөтэй хэмээх Баян-улаан уулын нэрээр нэрлэгдсэн болно.
- 5.
- 6.
7. БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн 1974 оны 7-р сарын 27-ны өдрийн 204 дүгээр зарлигаар Хэрлэн-Баян-улаан хороог байгуулсан. Мөн оны 12 дугаар сарын 27-нд БНМАУ-ын СнЗ-ийн 561 дүгээр тогтоолоор отор тэжээлийн станцын Отор тэжээлийн аж ахуй болгон өргөтгөжээ.
8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдагва, УБ, 1998.

## **50. Сүмбэр**

1. Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум.
2. 1969 онд байгуулагдсан.
3. 1992 онд өмч хувьчлалын тухай хуулиар хувьчилагдсан болно. Говьсүмбэр аймгийг байгуулахад түүний бүрэлдэхүүнд Сүмбэр сум болж байгуулагдсан.
4. Сүмбэр уулын нэрээр нэрлэгдсэн.
- 5.
6. Хар хонийг өсгөх зорилгоор анх байгуулагдсан. Хар хонины арьсыг хурганд нь авч үслэг эдлэлийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний хэрэгцээг хангаж байсан.
7. Хуучин Оцол-Сансар уулын хошуу буюу Монголын бурханы шашины томоохон төв Чойрын хийдийн байрлах нутагт байгуулагдсан.
8. Говьсүмбэр аймгийн үндэсний вэб хуудас.

## **51. Чандгана**

1. Хэнтий аймгийн Өлзийт хороо.
2. БНМАУ-ын СнЗ-ийн 1976 оны 10 сарын 19 ны өдрийн 357-р тогтоолоор байгуулжээ.
3. 1992 он.
4. Хэнтий аймгийн нутагт орших Чандганы талын нэрээр нэрийдсэн.
- 5.
- 6.
7. Үр тариа тарих, нарийвтар ноост хонь үржүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.
8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Сономдагва, УБ, 1998.

## 52. Хурх

1. Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сум.
2. 1981 онд байгуулагдсан.
3. 1992 онд татан буугдсан.
4. Хурхын талын нэрээр нэрлэгдсэн.
5. Анхны даргаар Архангай аймгийн Чулуут сумын харьяат Монгол улсын гавьяат эдийн засагч Чулуунбаатар ажиллаж байсан.
- 6.
7. Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Батноров, Батширээт гурван сумын зааг нутгаас хуваан байгуулсан билээ. Мөн 1980-аад онд нэмж байгуулагдсан цөөн САА нэг юм.
- 8.

## 53. Өндөрхаан

1. Хэнтий аймгийн төв Өндөрхаан хот.
2. БНМАУ-ын СнЗ-ийн 1954 оны 5 сарын 18-ны өдрийн 187-р тогтоолоор анх САА-г байгуулжээ.
3. 1992 он.
4. Төв нь Буянт.
5. Тус САА-г бий болгосон хүн бол анхны дарга Өлзийтогтох, намын зохион байгуулагч Ёндон нар том үүрэг гүйцэтгэжээ.  
Малчин зохиомол хээлтүүлэгч Агваанбалдан дөрвөн жил дараалан 3000-5000 хонь хээлтүүлж, нэг хуцаар 250-400 хонь зохиомлоор хээлтүүлж, жил бүр хонио 80-92 хувь хээл авахуулсан байна.
6. ЗИС-5, ГАЗ-51, ГАЗ-63 зэрэг ачааны машин 10, ХАА-н төрөл бүрийн машин 30 гаруйтай болжээ. 1954-1955 онд анх эрдэнэ шиш 50 га, арвай 72 га, овьёос 93 га-д тариалж, ажил үйлдвэрлэлээ эхэлжээ.
7. Анхлан 42 орон тоотойгоор байгуулав.
8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдагва, УБ, 1998.

## 54. Түмэнцогт

1. Сүхбаатар аймгийн Түмэнцогт сум.
2. 1960 онд байгуулагдсан.
3. 1992 онд татан буугдсан бололтой.
4. Түмэнцогт уулын нэрээр нэрлэгдсэн.
- 5.
- 6.
7. Улаанбаатархотоос 490 км, Баруун-Ургаас 140 км, Дорнод аймгийн төвөөс 200 км, Хэнтий аймгаас 150 км зайтай оршдог. Тус сум нь 250 мянган га



нутаг дэвсгэртэй, хойшоо урагшаа 55 км, баруун зүүн тийш 50 км, хилийн нийт урт нь 213 км байна. Түмэнцогт суманд Хар ямаатын уул, Инээдэг хад, Арслан хад, Жамбалнавгийн агуй зэрэг байгалийн өвөрмөц тогтоц бүхий үзэсгэлэнт газрууд байдаг. Мөн хуучин ашиглаж байсан гянтболд жоншны орд газруудаас гадна, шохойн чулуу, гематит, шаазангийн шавар, занар зэрэг 30 гаруй төрлийн эрдэс чулуулаг, байгалийн нөөц байна. Тус суманд хялгана хээр зонхилон тархсан 400 гаруй зүйл ургамал ургадгаас 80 гаруй зүйлийн эмийн ургамал ургадаг. Тухайлбал, Монголын улаан номонд орсон ховор ургамлаас монгол догор, алтангагнуур, гүйлс, эмийн алтан цэгцүүхэй, зэрлэг сармис, гандигар зэргээс гадна агь, таана, мангир, хөмөл, улаансонгино, зэрэг шүүст ургамал, хазаар өвс, ерхөг, хиаг, бударгана, зээргэнэ, хонгорзул, суль, зэрэг бэлчээрийн ургамал ургадаг.

8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдагва, УБ, 1998.

## **55. Баян-уул (Онон)**

1. Дорнод аймгийн Баян-уул сум.
2. 1950 онд анх Онон сангийн аж ахуй нэртэйгээр байгуулагджээ.
3. 1990-ээд он.
4. Онон голын дагуу байгуулагдсан.
- 5.
- 6.
7. Бэлчээр-тэжээлийн чиглэлээр ажиллаж байсан.  
1961 онд “Холбоо” нэгдлийг татан буулгаж Онон сангийн аж ахуйд нэгтгэсэн байна.
8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдагва, УБ, 1998.

## **56. Чулуунхороот (Эрэнцэв)**

1. Дорнод аймгийн Чулуунхороот сум.
2. 1957 онд анх байгуулагдсан.
3. 1992 он.
4. 1959 онд САА-г шинэ засаг захиргаанд оруулж сумыг Чулуунхороот гэж нэрлээд, сангийн аж ахуйг Эрэнцав гэж нэрлэхээр тогтжээ.
5. Сангийн аж ахуйн анхны даргаар Бат-Очирын Нядаа томилогдон ажиллаж байжээ. Агротехникчээр Доржцэрэнгийн Жигмэд.
6. 1972 онд тус САА-д засварын газрын ЗХУ-ын тусламаар байгуулав.
7. Үр тариа, мал аж ахуйг хослуулан эрхлүүлэх зорилгоор СнЗ-ийн тогтоолоор 1961 онд нутгийн дундаж газрыг бодон Эрэнцавд шилжсэн. Хонь үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг. ЗХУ-ын тусламжтайгаар

САА-г иж бүрнээр барьж саалийн механикжсан фермүүд, үхэр бордох талбай зэргийг байгуулжээ.

8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдагва, УБ, 1998.

## **57. Хэрлэн**

1. Дорнод аймгийн Хэрлэн сум.
2. 1959 онд байгуулагдсан.
3. 1992 он татан буугдсан.
4. Хэрлэн голын нэрээр нэрийдсэн.
- 5.
6. 1968 онд тус САА-д ЗХУ-ын тусламжтай хөдөө аж ахуйн авто засварын газар байгуулсан.
7. Төмс хүнсний ногоо, газар тариалангийн чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг байж.  
30000 өндөглөгчтэй жилд 6-10 сая өндөг үйлдвэрлэх хүчин чадалтай фермийг байгуулж байсан.
8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдагва, УБ, 1998.

## **58. Салхит гэжээлийн аж ахуй**

1. Сүхбаатар аймгийн Баруун-урт хот.
2. 1961 онд байгуулагдаж илгээлтийн эздийг ажиллуулж эхэлсэн.
- 3.
4. Салхит хэмээх газрын нэрээр нэрлэгдсэн.
- 5.
- 6.
- 7.
8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдагва, УБ, 1998.

## **59. Сүмбэр**

1. Дорнод аймгийн Халх гол сум.
2. 1972 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр БНМАУ-ын СнЗ-ийн 7 дугаар тогтоолоор Дорнод аймгийн “Халх гол” Сангийн аж ахуй нэртэйгээр анх байгуулагджээ. САА 1975 онд ашиглалтанд оржээ.
3. 1992 онд Халх гол сумын баг болсон.
4. Сүмбэр уулын өмнө талд.
5. 1981 онд трактор-комбайнч Р.Пүрвээ хөдөлмөрийн баатар болов.
6. Төмс хүнсний ногоо, газар тариалангийн чиглэлийн үйл ажиллагаа

явуулдаг байж.

Хөрсийг эвдэрлээс хамгаалах зурваслан тарих аргыг САА-н талбайн 30-80 хувьд хийж байжээ.

Автомат усалгуур бүхий 400-1000 га услах хүчин чадалтай услалтын системийг байгуулж малын тэжээл, төмс хүнсний ногоо тариалж байсан. 1978 онд тус САА-д үхэр бордох байгууламжийг ЗХУ-ын тусламжаар байгуулжээ. ЗХУ -ын тусламж, тэдний барилгачдын шаргуу хөдөлмөрөөр сүндэрлэн боссон тус сангийн аж ахуй махны чиглэлийн үхэр үржүүлэн өсгөх, усалгаагүй болон усалгаатай нийт 17 мянган га эргэлтийн талбайд малын тэжээл, үр тариа тариалж жилдээ 13,0 мянган тонн өвс хадах чадалтай өвч механикжсан хадлангийн бригад ажиллаж байжээ. 1978 оны байдлаар 18000 мянган га эргэлтийн талбайд жил бүр 13000 га тариалан эрхэлж байна.

7. 1972 оны 6 дугаар сарын 20-ны өдөр БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн 117-р зарлигаар Халх гол дахь туршилтын станцыг харьяалсан хороог “Сүмбэр” гэж нэрлэн САА-г давхар харьяалах сум болгов.  
ЗХУ-ын тусламжтайгаар САА-г иж бүрнээр барьж саалийн механикжсан фермүүд, үхэр бордох талбай зэргийг байгуулжээ.  
1981 онд мал бордолгын аж ахуйг бүрэн байгуулж дуусгасан.
8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдагва, УБ, 1998.

## **60. Шарын голын (Дархан) САА**

1. Дархан-уул аймгийн Орхон сум.
2. 1959 онд ЗХУ-ын тусламжтай МЗН-ын нэрэмжит Дархан элит үрийн САА-г байгуулжээ.
3. 1992 онд татан буугдсан.
- 4.
5. ЗХУ-ын мэргэжилтэн М.В.Круть зөвлөх даргаар ажиллаж байсан.
6. Тус сум нь одоо 37,060 малтай ба өндөр ашиг цимтэй тахиа, гахай, үхрийн фермтэй.
7. 12-20 хүний бүрэлдэхүүнтэй 1980-иад оны сүүлч хүртэл ажилласан.
8. Сэлэнгийн түүхийн товчоон, Ө.Бавуу, Сүхбаатар, 2001.

## **61. Эг-Үүр**

1. Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сум.
2. 1959-1960 онд байгуулагдсан.
3. 1992 он.
4. Эг голын хөвөөнд.
5. Ямаачин Санжаажамц жил бүр 500-550 ямаа бойжуулж 100 хувь

бойжуулсан.

6. Эг-Үүрийн САА 1960 онд 1000 га-д анхны үр суулгаж, намар нь 3900 тонн үр тариа хураан авч байжээ.
7. 1963 оны БНМАУ-ын СнЗ-ийн тогтоолоор САА-н үйлдвэрлэлийн чиглэлийг өөрчлөж, сүүний чиглэлийн үхэр үржүүлэх САА болгосон. 1975 онд СнЗ-ийн тогтоолоор Эг-Үүрийн САА-г Тариалангийн САА болгон цомхотгожээ. БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн 1985 оны 11 сарын 5-ны өдрийн 240 дүгээр зарлигаар Эг-Үүрийн САА-г дахин байгуулжээ.
8. Монгол улсын засаг, захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1991-1997), Ц.Содномдагва, УБ, 1998.  
Хөвсгөл аймгийн товч түүх, С.Бадамхатан, Ч.Банзрагч, Мөрөн, 1961.

## 62. Улз

1. Дорнод аймгийн Баянтүмэн сум.
2. 1930 оны 4 сарын 7 хуралдсан Улсын ҮИ хурлын шийдвэрээр Улз САА юм. 1931-1932 онд үед зүүнтний алдаа завхарлын үед САА-д олноороо алдагдалтай ажилласан учир 1933 үйл ажиллагаа нь ихээхэн хумигджээ. 1960 онд үржил зохиомол хээлтүүлгийн улсын станц нэртэйгээр байгуулсан.
3. 1992 он.
4. Улз голын хөндий дагуу.
- 5.
6. Анх байгуулахад ЗХУ-аас сайн угсааны меринос хонь 1330, дотоодоос 30000 мянган эм хонь худалдан бэлтгэж олгосон байна. 1974-1990-ээд онд 400 үнээний саалийн ферм, 1000 га-гийн талбайн услалтын систем зэргийг ашиглаж байжээ.
7. Төмс хүнсний ногоо, газар тариалангийн чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг байж.
8. БНМАУ-ын ХАА-н 60 жилд, Т.Бямбаа, УБ, 1982.

## 63. Тамсаг булаг

1. Дорнод аймгийн Матад сум, Халх гол сумын заагт орших нутаг бий.
2. 1954 онд хуралдсан БНМАУ-ын СнЗ-ын 180-р тогтоолоор байгуулагдсан.
- 3.
4. Тамсаг булаг гэх газарт байна.
- 5.
6. 1960 оны нэгдүгээр сард Сайд нарын Зөвлөлийн 19 дүгээр тогтоолоор Тамсагбулагийн САА нь Сүхбаатар аймгийн Хан-Хөхий уулын өвөрт Хар ямаатын гянт болдын уурхайн суурин дээр шилжин суурьшжээ. 1972 оноос газар тариалангаас гадна нутгийн шилмэл үхэр үржүүлэх болсноор

мал аж ахуй, газар тариалан хосолсон аж ахуй болсон байна. 1978 онд ЗХУ-ын хүч хөрөнгөөр сумын төвийг тохижуулж соёлын төв, 110 айлын орон сууц, хүүхдийн цэцэрлэг, сургууль, дотуур байр, эмнэлэг бүхий орчин үеийн тохилог суурин болсон байна.

7. Нарийвтар ноост хонь ба үхэр үржүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг байв.
- 8.

#### **64. Халиун буга**

1. Улаанбаатар хотын Богд уулын орчим.
2. 1964 он.
3. 1992 он.
4. Богд хан уулын өвөрт оршино.
- 5.
- 6.
7. Бэлчээрээр үржүүлж, цусан эвэр ашиглах зорилгоор байгуулагдсан.
8. БНМАУ-ын САА-нууд, Д.Мандалсүрэн, УБ, 1969.

#### **65. Сөгнөгөр**

1. Төв аймгийн Батсүмбэр сум.
2. 1931 онд Цэргийн ба Мал тариалангийн яамны морин заводыг нийлүүлж анх байгуулжээ.
3. 1992 оны өмч хувьчлалын үеэр хэдэн хүмүүс хувьчлан аваад хувиараа АА явуулж байгаа.
4. Сөгнөгөр гол.
- 5.
- 6.
7. Адуу үржүүлгийн чиглэлтэй. Анх байгуулагдахад Английн цэвэр үүлдрийн азарга 30-ыг авчирч эрлийзжүүлэх ажлыг зохион байгуулж эхэлжээ.
8. БНМАУ-ын Сангийн аж ахуйнууд, Д.Мандалсүрэн, УБ, 1969.  
Төв аймгийн газар тариалан 50 жилд, М.Эрдэнэдалай, Ж.Сүрэнхорлоо, Зуунмод, 2009.

#### **66. Төрхурах**

1. Улаанбаатар хотын орчим.
2. 1963 оны орчим байгуулагдсан.
3. 1992 он.
4. Улаанбаатар хотоос өмнө зүгт Налайх хот явах замын баруун гар талд орших Төр хурахын аманд байгуулагдсан учир ийн нэрийдсэн.
- 5.

- 6.
7. Үслэг ан үржүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байсан.
8. БНМАУ-ын Хөдөө аж ахуй 60 жилд, Т.Бямбаа, УБ, 1982.

## **67. Баянтооройн ТАА**

1. Говь-алтай аймгийн Цогт сумын нутаг.
2. 1987 оны БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1987 оны 4 сарын 3-ны өдрийн 129-р тогтоолын дагуу 1987 оны 4 сарын 16-ны өдөр Баянтоорой Тэжээлийн аж ахуй байгуулагджээ.
3. 1996 онд хувьчлагдаж Тоорой бүрд ХХК болон үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн шинэ технологи, шилдэг үйлдвэрлэлийг нэвтрүүлж Алтай нутгийн бизнесмен Батжаргал удирдаж байна.
4. Тоорой хэмээх говьд ургадаг мод бухий газарын нэрээр нэрлэгдсэн.
5. Баянтооройн Тэжээлийн аж ахуй байгуулагдахад анхны даргаар нь Л.Дашдаваа, Т.Арилдий, С.Шагдар, Ерөнхий нягтлан бодогч Г. Намнансүрэн, ерөнхий агрономич Л.Бадарч, Д.ариунмөнх, Б.Мягмаржав нар ажилласан байна. Тус Тэжээлийн аж ахуйгаас Ж.Гомбо Улсын аврага, Б.Рэнцэн, З.Донров, О.Дашцэрэн, Н.Батдорж, Санжсүрэн нар алтан гадас одонгоор Д.Батчулуун, А.Цэвэгмид Балдан, Намжилсүрэн, Мөнх-Очир нар Засгийн газрын шагнал авч байжээ. Б.Шазэвэг анх Цогт сум нэгдлийн дарга байхдаа Шугуй, Хаяагийн услалтын системийг санаачилан тэжээлийн аж ахуйн үндсийг тавьжээ.
6. Анх 800 гаруй га талбайтай, малын тэжээл үйлдвэрлэх үндсэн зорилготойгоор мал аж ахуй, жимс ногооны тариалалт эрхлэн үйл ажиллагаагаа эхэлжээ. Захуйн говьд улаан буудай, эрдэнэ шиш, арвай тарьж, гурил, малын тэжээл үйлдвэрлэж, хүн, мал амьтны хүнс идэж, тэжээлээр хангаж байв. Үүнээс гадна бэсрэг алим, чацаргана зэрэг жимсний модыг тарималжуулж алим жимсийг худалдан борлуулах, хүнсний үйлдвэрлэл явуулж байв. Одоо жилдээ 2-12 тонн жимс жимсгэнэ хураан авч, хоногт 8-12 тонн гурил үйлдвэрлэх хүчинтэй гурилын үйлдвэр, эсгийний үйлдвэр, арвайн гурил, ундаа нарийн боов, савангийн цехүүд ажиллаж байна. Нарийн хүнсний ногооны цехүүд ажиллуулж байна.
7. Тус Тэжээлийн аж ахуйг байгуулсан шалтгаан нь баруун бүс нутгийн малын тэжээлийн бааз суурийг нэмэгдүүлэх, усалгатай тариаланг хөгжүүлэх, дулааны хангамжид тулгуурлан жилд 2 удаа ургац авах зорилгоор байгуулжээ. Тус ТАА-н газар тариалангийн үйлдвэрлэл явуулдаг бүс нутаг нь Захуйн говь бөгөөд ургамлын ургалтын хугацаа 120-160 хоног, дулааны улиралд 42-45 градус, хөрсөндөө 69 хүртэл халдаг мөртлөө хур тундас, усан хангамж муутай, говь цөлийн хөнгөн хөрс зонхилсон бүс нутаг юм. Нутгийн иргэд мал аж ахуй, газар тариалангийн хосолсон

- жижиг аж ахуй эрхэлж байсан уламжлал бий. Энэ бүс нутагт газар тариалангийн томоохон бүтээн байгуулалт өрнүүлж, Алтайн нурууны өндөр уулсын цас, борооны усны хуримтлалаас 34 м өндөр шороон боомт бүхий усан цогцолбор, услалтын системүүд байгууламж 1000 шахам га талбайд тариалалт явуулж зарим жилд 2 удаа ургац авч байсан туршлагатай.
8. Баянтооройн САА-д Говийн Дархан цаазат газрын даргаар ажиллаж байсан А.Авирмэдээс тодруулсан аман түүхийн мэдээ.

## **68. Дархан САА**

1. Дархан-уул аймгийн Хонгор сум 1932-1959 онд Дархан сум нэртэй байсан. 1959 оноос Хонгор нэртэй болсон. Сумын төв нь Буурал.
2. 1965 оноос Сэлэнгэ аймгийн Хонгор суманд “Дархан” САА харьяалагджээ. 1982-1992 оны хооронд Дархан хотын Хонгор хороо, Дархан САА нэртэй байжээ.
3. 1994 онд Дархан-Уул аймгийн Хонгор сум гэж байгуулагдсанаар “Дархан” САА татан буугдсан байна.
4. Шинээр байгуулагдсан сумын төвийг тус сумын нутаг дэвсгэр дээр байгаа эртний тахилгат Буурал уулын нэрээр нэрлэжээ. Анх сум САА байгуулагдахад сумынхаа нэрийг Дарханы хойхно орших Ноёнхонгор уулын нэрээр нэрлэсэн боловч “тэр үеийн үзэл сурталчид Ноён” гэдэг үгнээс цэрвэж “Хонгор” гэж нэрлэхээр тогтжээ.
5. Атрын анхны шанг 1959 оны 3 дугаар сард одоогийн шинэ хуучин хоёр Дарханы хоорондох Хөтөлөөс Бурхантын хөндий хүртэлх газрыг Хонгор сумын хоёрдугаар багт амьдарч байгаа Далайн Ланцав ДТ-54 трактороор татсан. САА-н үе үеийн удирдлага САА-н дарга А.Бадарчин, Б.Санжаажамц, Маршал Х.Чойбалсангийн комиссар байсан Д.Загдгочоо, атрын анхдугаар аяны агрономич Д.Чулуун, хөдөлмөрийн баатар Жанчив, ерөнхий агрономич Бадамцэрэн, ерөнхий инженер гавьяат механикжуулагч О. Рэнцэнханд, ерөнхий зоотехникч Ч.Гэндэнжав, малын их эмч Н.Дорж, Тэрбиш зэрэг хүмүүс ажиллаж байв. Дарханы САА 1968 онд Дархан хотын төвөөс нүүж Сум-Сангийн аж ахуйн төвийг барьж байгуулан одоогийн Хонгор сумын нутагт нүүж ирсэн. Атрын анхны ургацын дээжээр хийсэн 20 кг жинтэй том талхыг тэр үед Ардын их хурлын тэргүүлэгчдийн дарга байсан Ж.Самбуу гуайд гардуулж байсан.
6. Үр тарианы 8 бригадтай, Дарханы Хөдөлмөрчдийг сүүгээр хангах зорилгоор мах, сүүний семанталь цэвэр үүлдрийн 800 үнээний хүчин чадалтай саалийн иж бүрэн механикжсан “Төвийн” ферм, Шарын голыг хангах зориулалттай “Бууртын” 400 үнээний ферм ажиллаж байв. Хонгор сум нь 253.3 мянган га нутаг дэвсгэртэй, энэ нь нийт аймгийн газар нутгийн 77 хувийг эзэлдэг гэсэн үг юм. 32.1 мянган га тариалангийн эдлэн

талбайтай, 5.1 мянган хүн амтай, 1400 гаруй өрхтэй, хүн амын 17 хувь буюу 656 нь Казах иргэд эзэлдэг. 124.4 толгой малтай. Нийслэлээс 195 км, аймгийн төвөөс 25 км зайтай.

7. 1977 оноос Монгол-Зөвлөлтийн найрамдлын САА болж, 1988 оноос шилдэг үрийн САА гэж нэрлэгдэж байв. Атар газар эзэмших анхы аянаар 1959 оны 3-р сард байгуулагдсан дөрвөн САА-н нэг. САА байгуулагдахаас өмнө Сэлэнгэ аймгийн Дархан сум-Монгол Зөвлөлтийн найрамдлын нэрэмжит нэгдэлийн зүүн хэсгийн нутгийг Атрын анхдугаар аяны түшиц газар болгож, шинэ сум САА байгуулах тухай асуудлыг аймаг орон нутгийн удирдлагаас Засгийн газарт оруулан хэлэлцүүлж батлуулжээ. Засгийн газрын шийдвэрийн дагуу Сэлэнгэ аймгийн Хонгор сум-Дархан САА-г байгуулж, ЗХУ-ын хүч хөрөнгөөр тохижуулан Монгол Зөвлөлтийн найрамдлын нэрэмжит САА болгожээ.

8.